



Sainshand Salkhin
Park LLC

САЙНШАНД САЛХИН ПАРК ТӨСӨЛ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ



Баталсан:

Төслийн менежер

Бэлтгэсэн:



Тэкол ХХК

Shared Resources Pty Ltd

Д.Нандинбаяр

Н.Оюунчимэг

Л.Лиз

**Улаанбаатар хот
2017**

Ерөнхий мэдээлэл:

Төслийн нэр:	Сайншианд салхин парк
Үйлчлүүлэгч:	Сайншианд салхин парк ХХК
Байршил:	Дорноговь аймаг, Сайншианд
Баримт:	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
Мэдээллийн ангилал:	Нууцлалтай
Бэлтгэсэн:	Тэкол ХХК ба Shared Resources Pty Ltd
Огноо:	2017 оны 2 сарын 10
Эмхэтгэсэн:	Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Оюунчимэг
Хянасан:	Төслийн менежер Д.Нандинбаяр Төслийн ахлах менежер Федерика Пелзер

Тэкол ХХК нь Төслийн хөгжлийн төлвийг нарийвчлан авч үзэн, энэхүү баримтыг ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт, ЕХОБ-ны байгаль орчин, нийгмийн стандарт болон Монгол улсын үндэсний хууль тогтоомжуудын шаардлагад нийцүүлэн бэлтгэв.

Нэмэлт өөрчлөлт хийсэн тухай тэмдэглэл

Өөрчлөлтийн дугаар	Огноо	Өөрчлөлт хийсэн шалтгаан	Хийгдсэн өөрчлөлт
1	2016-6-17	Эхний ноорог	-
2	2016-6-24	Үйлчлүүлэгч, орон нутгийн засаг захиргаа болон малчдаас нэмэлт мэдээлэл авсан.	Тайланг дуусгасан.
3	2016-8-10	Үйлчлүүлэгчийн санал, тайлбар	Үйлчлүүлэгчийн саналын дагуу засвар оруулсан.
4	2016-8-19	Үйлчлүүлэгчийн санал, тайлбар	Үйлчлүүлэгчийн саналын дагуу засвар оруулсан.
5	2016-10-4	Үйлчлүүлэгчийн санал, тайлбар	Үйлчлүүлэгчийн саналын дагуу засвар оруулсан.
6	2016-11-4	Зээлдүүлэгчийн санал, зөвлөмж, шинэ мэдээллийг оруулах, нүүлгэн шилжүүлэлтийг тусган харуулах	Зээлдүүлэгчийн санал, зөвлөмж, шинэ мэдээллийг оруулахын тулд Тэкол ХХК болон Shared Resources Pty Ltd компаниуд уг баримт бичгийг шинэчлэн өөрчилж, нүүлгэн шилжүүлэлтийг тусган харуулсан.
7	2016-11-11	Трубины сүүдэрлэлтийн анализыг шинэчлэх	Трубины сүүдэрлэлтийн зургийг сольсон.
8	2017-2-10	Нийгмийн суурь үнэлгээний талаарх зарим мэдээллийг шинэчлэх	Нийгмийн суурь үнэлгээнд бага зэргийн засвар оруулсан.

Энэхүү тайлангийн тухайд

Энэхүү тайланг Сайншанд салхин парк ХХК-ийн (“Үйлчлүүлэгч”) хэрэгцээнд зориулан Монгол улсад хэрэгжих Сайншанд салхин парк төсөлтэй холбогдуулан Тэкол ХХК ба Shared Resources Pty Ltd бэлтгэсэн. Тайланг дараах нөхцөлийн дагуу уншиж танилцана.

Энэ баримт бичгийг төслийн сүлжээгээр дамжуулан бүх ажилтан, албан хаагч авч ашиглах боломжтой. Тогтмол хянаж, шинэчлэгдсэн сүүлийн хувилбарыг цахим хэлбэрээр үзэх боломжтойгоос гадна Үйлчлүүлэгчээс өгсөн бичгэн зөвшөөрөлд үндэслэн бүх сонирхогч талуудад өгч болно.

Уг төлөвлөгөө шинэчлэх, хадгалах үүргийг төслийн байгаль орчны ажилтан хариуцна. Төлөвлөгөөний эх хувийг гарын үсгээр баталгаажуулж, төслийн бичиг баримтын санд хадгалах шаардлагатай. Хэрэв танд энэ төлөвлөгөөтэй холбоотой лавлах зүйл байвал эхлээд төслийн байгаль орчны ажилтантай холбогдоно уу.

Гарчиг

1	ТАНИЛЦУУЛГА	8
1.1	Оршил.....	8
1.2	Ерөнхий тойм.....	9
1.3	Төслийн ерөнхий танилцуулга.....	10
1.4	Төслийн үр өгөөж.....	11
2	ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА.....	13
2.1	Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам:	13
2.2	Олон улсын шаардлага	15
2.2.1	Оршил.....	15
2.2.2	Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт.....	15
2.2.3	Экваторын зарчмууд	16
2.2.4	Европын хөрөнгө оруулалтын банк.....	16
2.3	Монгол улсын хууль тогтоомж ба ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартын ялгаа.....	17
3	НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	20
3.1	Мэдээллийн эх сурвалж.....	20
3.2	Засаг захиргааны нэгж	20
3.3	Хүн амзүйн гол онцлог	21
3.4	Монголын нүүдэлч малчдын амьдралын хэв маяг, онцлог.....	21
3.5	Нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхийн онцлог шинж.....	22
3.5.1	Нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхийн хүн амзүйн онцлог.....	22
3.5.2	Нас, хүйсийн байдал	23
3.5.3	Боловсрол.....	23
3.5.4	Ажил эрхлэлт.....	23
3.5.5	Монгол гэрийн онцлог.....	24
3.5.6	Усны эх үүсвэр	24
3.6	Судалгаанд хамрагдсан өрхүүдийн эдийн засгийн байдал	25
4	ТӨСЛИЙН ГАЗРЫН НӨЛӨӨЛӨЛ.....	28
4.1	Аюулгүйн зай/бүс.....	28
4.1.1	Дуу чимээ	28
4.1.2	Сэнсний далавч унах, түүнээс цас, мөс шидэгдэх эрсдэл	28
4.1.3	Сэнсний сүүдэрлэлт	29
4.1.4	Сайншанд салхин цахилгаан станцын аюулгүйн бүс	30
4.1.5	Төслийн газрын шаардлага.....	31
4.2	Төслийн нөлөөллийн тодорхойлолт	32

5	НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ	38
5.1	Гол зарчим	38
5.2	Газрын хязгаарлалтыг багасгах.....	38
5.3	Нөхөн төлбөр ба түүнийг олгох нөхцөл.....	38
5.3.1	Бодит нүүлгэн шилжүүлэлт (Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл А)	38
5.3.2	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт (Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл С).....	40
6	ОРОЛЦОО БА САНАЛ ГОМДЛЫН МЕХАНИЗМ	42
6.1	Сонирхогч тауудын оролцоог хангах үйл ажиллагаа	42
6.2	Санал, гомдлын механизм	43
6.2.1	Оршил.....	43
6.2.2	ССП-ын санал, гомдлын процесс	44
6.2.3	Санал гомдлыг хүлээж авах	45
6.2.5	Хариу арга хэмжээг тодорхойлох	47
6.2.6	Санал гомдлыг тэмдэглэн, хянах	47
6.2.7	Үүрэг хариуцлага	48
7	МОНИТОРИНГ БА ҮНЭЛГЭЭ.....	49
7.1	Мониторинг	49
7.1.1	Дотоод мониторинг	50
7.1.2	Үр дүнгийн үнэлгээ.....	51
7.1.3	НШТ-ний хэрэгжилтэд хийх аудит	52
7.2	Тайлагнах	53
8	ТӨСӨВ.....	54
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	55
	Хавсралт А: Өрхийн судалгааны хуудас.....	57
	Хавсралт Б: Олон нийтийн санал, гомдлын хуудас	58

Хүснэгтүүд

Хүснэгт 2.1 Монгол улсын хууль тогтоомж ба ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартын ялгаа.....	17
Хүснэгт 3.1 Байнгын оршин суугчид	21
Хүснэгт 3.2 Судалгаанд хамрагдсан 7 өрхийн гишүүдийн нас, хүйсийн бүтэц.....	23
Хүснэгт 4.1 Сайншанд салхин парк төсөл хэрэгжих талбайн хэмжээ, сумдаар	31
Хүснэгт 4.2 Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл	32
Хүснэгт 4.3 Судалгаанд хамрагдсан өрхүүдийн өвөлжөө ба зуслангийн байршил.....	36
Хүснэгт 4.4 Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн урьдчилсан тойм	37
Хүснэгт 5.1 Нөхөн төлбөр олгох нөхцөл, түүнийг авах эрх ба төлбөр	40
Хүснэгт 5.2 Эмзэг бүлгийн өрхүүд.....	41
Хүснэгт 7.1 Дотоод мониторингийн бүтэц	51
Хүснэгт 7.2 Тайлан.....	53
Хүснэгт 8.1 Төсвийн тойм	54

Зургүүд

Зураг 1.1 Төслийн талбайн байршил	10
Зураг 1.2. Төслийн газар ашиглалтын схем	11
Зураг 3.1 Алтанширээ, Сайншанд, Өргөм сумдын төв.....	21
Зураг 4.1 Сайншанд салхин цахилгаан станцын сэнсний сүүдэрлэлтийн загвар	30
Зураг 4.2 Аюулгүйн бүс.....	31
Зураг 4.3 Төслийн талбайн дүр зураг	32
Зураг 4.4 Төслийн талбайн ойролцоох өвөлжөөний байршил.....	34
Зураг 4.5 Төслийн талбайн ойролцоох өвөлжөөний томруулсан зураг	35
Зураг 4.6 Төслийн ойролцоох зуслангийн газрын байршил	36
Зураг 6.1 Санал, гомдлын механизмын үе шатууд	45
Зураг 7.1 Мониторинг ба үнэлгээ хийх хугацаа	52

Үгийн тайлбар ба товчилсон үгийн жагсаалт

%	хувь
га	га (=10,000 кв.метр)
км	километр
м	метр
МВт	мегаватт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОННУ	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
БОНУТ	Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцооны
БОНУ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
ГС	Гүйцэтгэлийн стандарт
ДБ	Дэлхийн банк
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
НШТ	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ОУСЭХА	Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг
СЦҮ	Салхин цахилгаан үүсгүүр
ССП төсөл	Сайншанд салхин парк төсөл
ССП компани	Сайншанд салхин парк компани
СТОХТ	Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ФФ	Финфанд
ХБОЗХОС	Хөгжиж буй орнуудад зориулсан хөрөнгө оруулалтын сан
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЭЗ	Экваторын зарчим
ЭЗСБ	Экваторын зарчим санхүүгийн байгууллага
ЭКФ	Экспорт кредит фонден

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Оршил

Сайншанд салхийн парк ХХК нь Монгол орны говийн бүсэд 55 МВт хүчин чадал бүхий салхин цахилгаан станц байгуулахаар Германы Ferrostaal Industrial Projects GmbH компани (хувьцааны 67%) болон Монгол улсын хэд хэдэн хувийн хөрөнгө оруулагч нартай (хувьцааны 33%) хамтран ажиллаж байна. Төсөл нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 450 км зайд орших Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын уулзвар нутаг, Улаан толгойн хөндий гэх газарт хэрэгжих ба ССП нь энэ нутагт 486.6 га газрыг 30 жилийн хугацаатай ашиглах зөвшөөрөл авсан. Төсөл хэрэгжих 25 трубин буюу салхин цахилгаан үүсгүүр (СЦҮ) суурилуулах юм.

Төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг (БОННУ) 2009 онд Байгаль-Экологи ХХК анх хийсэн. БОННУ-г хийлгэснээс хойш таван жилийн дотор дахин шинэчлэн хийлгэх ёстой гэсэн Байгаль орчин аялал жуулчлалын яамны (БОАЖ) шаардлагын дагуу уг үнэлгээг 2015 онд Байгаль Экологи компаниар дахин хийлгэсэн. Тус төсөл нь олон улсаас санхүүгийн дэмжлэг авахын тулд Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОНИНУ) болон холбогдох бусад баримт бичгүүдийг Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн шаардлагын (ГШ) дагуу боловсруулсан (2012).

Энэхүү Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг (НШТ) Сайншанд салхин парк (ССП) төслийн газар ашиглалтын үйл явц болон уг төслийн нөлөөнд өртсөн бусад эд хогшлын нөхөн төлбөрийн үйл явцын талаар тайлбарлан таниулах зорилгоор бэлтгэсэн болно.

НШТ нь дараах зорилготой. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэлт болон амьжиргааг дээшлүүлэхтэй холбоотой олон улсын стандартууд болон хууль эрхзүйн шаардлагын талаар тоймлон өгүүлэх;
- Төслийн улмаас учирч болзошгүй бодит болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийг тодорхойлох;
- Төслийн нөлөөнд өртсөн гэр бүлийн амьжиргааг дээшлүүлэх, ийм боломжгүй тохиолдолд өмнөх байдалд нь оруулахын тулд нөлөөлөлд өртсөн айл өрхийн судалгаа хийх;
- Төслийн нөлөөлөлд өртсөн эмзэг бүлгийн хүмүүсийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай нэмэлт арга хэмжээг тодорхойлох;
- Нүүлгэн шилжүүлэлт болон амьжиргааг дээшлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөг боловсруулах. Төслийн гомдол, санал, хүсэлт барагдуулах механизмыг боловсруулах;
- Мониторингийн болон үнэлгээний бүтцийг тодорхойлох.

НШТ-ний бүлгүүд нь дараах агуулын дагуу бичигдсэн болно:

Хоёрдугаар бүлэгт ССП Төслийн газар ашиглалт болон нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой Монгол улсын хууль, олон улсын стандартуудын шаардлагуудын талаар тайлбарлана.

Гуравдугаар бүлэгт Төслийн нөлөөнд буй бүс нутгийн нийгэм-эдийн засгийн талаар тоймлон танилцуулж, нөлөөлөлд өртсөн хүн амын нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлын талаар нарийвчилсан мэдээлэл өгнө.

Дөрөвдүгээр бүлэгт Төслийн газар ашиглалтын одоогийн болон ирээдүйн нөлөөллийн талаар өгүүлнэ.

Тавдугаар бүлэгт нөлөөлөлд өртсөн хүн амыг тодорхойлох, нөхөн төлбөрийн механизмыг боловсруулах гэх мэт Төслийн газар ашиглалтын нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар өгүүлнэ.

Зургаадугаар бүлэгт гомдол, санал, хүсэлт, маргааныг шийдвэрлэх механизм болон НШТ-ний хүрээнд хийгдэх олон нийтийн уулзалт хэлэлцүүлэг, мэдээлэл дамжуулах үйл явц, үйл ажиллагааг тайларлана.

Долоодугаар бүлэгт НШТ-ний мониторинг ба үнэлгээний талаар өгүүлнэ.

Наймдугаар бүлэгт НШТ-ний төсвийн хураангуйг тусган харуулна.

1.2 Ерөнхий тойм

Монгол орон бол эрчим хүчний эх үүсвэр, түүний дотор нүүрс, түүнчлэн салхи, нар, усны эрчим хүч гэх мэт сэргээгдэх эрчим хүчний арвин баялаг нөөцтэй¹. Хэдийгээр өнөөг хүртэл Монголд цахилгаан эрчим хүч, дулааны үйлдвэрлэл нүүрсний нөөцөд түшиглэж байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний салбар өргөжиж байна. Монголын анхны салхин цахилгаан станц - Салхитын салхин цахилгаан станц (52 МВт) 2013 онд ашиглалтад орж байсан бол Сайншандын салхин парк төсөл хоёр дахь салхин цахилгаан станцыг байгуулахаар ажиллаж байна. 2015 оны 6 сарын байдлаар Монгол улс нийт 1082 МВт (Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого, 2015-2030) эрчим хүчний үйлдвэрлэсэн бөгөөд цахилгаан эрчим хүчний хүлээн авах хэмжээ 98% байв.

Хотжилт хурдацтай өсөн нэмэгдэж буй өнөө үед хэрэглэгчдийг өндөр чанартай, өртөг багатай эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах хэрэгцээ шаардлага Монгол орны өмнө тулгараад байна. Өнөө цагт Монгол улсын эрчим хүчний салбарт тулгараад буй асуудал бол эрчим хүчний хомсдол, хуучирсан дэд бүтэц болон шугамын алдагдал юм².

Сайншанд салхин парк төсөл нь эрчим хүчний системийн чадавхийг нэмэгдүүлж, сэргээгдэх эрчим хүчний нэмэлт хангамжийг бий болгож, Говийн бүс хүртэлх эрчим хүчний дамжуулалтын алдагдлыг бууруулснаар дээрх асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

Монголын төрөөс сэргээгдэх эрчим хүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжихийн тулд сэргээгдэх нөөцөд түшиглэн эрчим хүч үйлдвэрлэж буй хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг татварын хөнгөлөлт, хууль эрхзүйн таатай орчин бүрдүүлэх замаар урамшуулж байна. Монгол улс сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээг 2020 онд 20%, 2030 онд 30% хүргэхээр зорьж байна.

ССП төсөл хэргэжсэнээр жилд 107.3 мянга гаруй айл өрхийн цахилгаан хэрэглээг хангах цэвэр эрчим хүчийг салхины хүчээр үйлдвэрлэснээр дулааны цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээс бий болох 222.2 мян.тн CO₂-ын ялгаруулалтыг бууруулах, 1.97 сая.м³ цэвэр ус, 78416 тонн нүүрсний хэрэглээг хэмнэх болно..

Түүнчлэн, ССП төсөл нь Монгол улсын эдийн засаг, эрчим хүчний зах зээлд өөрийн хувь нэмрийг оруулахын зэрэгцээ бүтээн байгуулалтын үе шатанд ажлын шинэ байр бий болгох гэх мэт шинэ боломжуудыг бий болгох юм.

¹ ОУСЭХА (2015) Сэргээгдэх эрчим хүчний бэлэн байдлын үнэлгээ, http://www.irena.org/DocumentDownloads/Publications/IRENA_RRA_Mongolia_2016.pdf


² Эрчим хүчний яам (2016) Монголын эрчим хүчний салбар: Тогтвортой хөгжлийн бодлого http://www.switch-asia.eu/fileadmin/user_upload/RPSC/event/23-25May16-Mongolia/23May/5_Yeren_Energy_English.pdf

1.3 Төслийн ерөнхий танилцуулга

Төсөл хэрэгжүүлэх талбай нь далайн төвшнөөс дээш 915-1005 метр өргөгдсөн “Улаан толгойн хөндий” хэмээх газарт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 460 км, Замын-Үүд хилийн боомтоос баруун хойш 232 км, Сайншанд сумын төвөөс зүүн урагш 7 км зайд оршино.

Төсөл хэрэгжих газрын байршлыг Зураг 1.1-т харуулав.

Зураг 1.1 Төслийн талбайн байршил



Салхин турбиныг Улаантолгойн хөндийн урд тал, Хэцүү цавийн хуурай сайр бүхий ухаа толгодын ар нуруу тэгшивтэр өндөрлөг дээр баруунаас зүүн тийш цуваа маягаар байруулна.

Монгол болон Зүүн Азийг Европтой холбодог Транс-Сибирийн төмөр зам Сайншанд сумыг дайран өнгөрдөг. Энэ төмөр зам нь Сайншандаас урагш явсаар Замын-Үүдийн хилийн боомт хүрч, улмаар Хятад улстай холбогддог (Байгаль-Экологи, 2015).

Төслийн техникийн нарийвчилсан үзүүлэлтүүдийг БОННУ-нд тусгасан бөгөөд 2014/A105 тоот үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгийний тухай хуулийн дагуу хийлгэж, 2015 оны 6 сарын 29-нд БОАЖЯ-аар батлуулсан.

Төсөл нь Сайншанд хотоос зүүн өмнөд зүгт 7 км зайтай газар 55 МВт-ын хүчин чадалтай 25 салхин трубин (салхин цахилгаан үүсгүүр) байрлуулна. Трубин тус бүр 2.2 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай.


Төсөл нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Салхин трубин – 25 ширхэг (Вестас загварын V 100 Вт, 2.2 МВт), цамхагийн өндөр 95 метр, ротор буюу сэнсний диаметр 110 метр
- Төслийн талбай дээрх дэд станц
- Салхин трубиныг хооронд нь болон төслийн талбай дээрх дэд станцтай холбосон газар доорх цахилгааны шугам сүлжээ

- Төслийн талбай дээрх дэд станцыг Сайншанд дахь дэд станцтай холбох 4 км урт цахилгаан дамжуулах шугам (110kV)
- Сайншанд хотод байрлах ажилчдын түр байр
- Салхин турбинуудыг хооронд нь холбосон зам болон төслийн талбай дээрх дэд станцыг хатуу хучилттай төв замтай холбосон 2 км зам

Төслийн газар ашиглалтын байдлыг Зураг 1.2-т харуулав.

Зураг 1.2. Төслийн газар ашиглалтын схем



Салхин турбиныг Улаантолгойн хөндийн урд тал, Хэцүү цавийн хуурай сайр бүхий ухаа толгодын ар нуруу тэгшивтэр өндөрлөг дээр баруунаас зүүн тийш цуваа маягаар байруулна.

1.4 Төслийн үр өгөөж

ССП төсөл нь Монгол улсын эрчим хүчний салбарт чухал ач холбогдолтойгоос гадна нутгийн иргэд болон орон нутгийн эдийн засагт тодорхой үр өгөөжөө өгөх юм. Тэдгээрийг урьдчилсан байдлаар дүгнэвэл:

- **Орон нутгийн иргэдэд ажлын байр бий болно.** Төслийн барилгын ажлын үед ойролцоогоор 200 хүний ажлын байр бий болно гэж үзэж байна. Ялангуяа төсөл хэрэгжих газарт хамгийн ойр байрлах суурингийн (ө.х, Сайншанд хот) иргэд түр ажлын байраар хангагдах боломж их байна.
- **Орон нутгийн дэд бүтэц сайжирна.** Төслийн барилгын ажилтай зэрэгцэн орон нутгийн дэд бүтцийн одоогийн нөхцөл байдал тодорхой хэмжээгээр сайжирна. Дэд бүтцийг сайжруулах засвар үйлчилгээний зориулалтаар зарим төрлийн барилгын материал

худалдаж авах шаардлага гарах бөгөөд энэ нь Төслийн зүгээс орон нутагт үзүүлэх томоохон үр өгөөжийн нэг юм.

- **Орон нутгийн эдийн засагт дэмжлэг үзүүлнэ.** Төслийн барилгын ажлын үеэр ажилчдын түр байранд байрлах барилгын болон инженер техникийн ажилчдын хүнс, өргөн хэрэглээний барааг орон нутгийн зах, худалдааны төвөөс хангах учраас хүнсний үйлдвэр болон худалдааны захуудын орлого нэмэгдэх боломжтой.

.

2 ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Монгол улсын түүхийн туршид газар зөвхөн төрийн мэдэлд байсаар ирсэн. Харин 1990 оны эхэнд явагдсан өөрчлөлт шинэчлэлтийн дүнд тус улс зах зээлийн эдийн засагт шилжиснээр төрийн энэ эрх харьцангуй суларсан. Дараах дэд хэсгүүдэд газар болон нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой Монгол улсын хууль эрхзүйн орчны талаар өгүүлнэ.

2.1 Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам³:

- **Монгол улсын Үндсэн хууль (УИХ-ын 1992 оны 10 сарын 17-ны өдрийн 41-р тогтоол)**
 - Үндсэн хуулийн 1-р бүлгийн 6-р зүйлд иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч гэж заасан.
 - Түүнчлэн бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно гэсэн байдаг.
 - Мөн төр нь улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно гэж заасан.
 - 2-р бүлгийн 10-р зүйлд төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөн олговор, үнийг төлнө гэж заасан байдаг.
- **Газрын тухай хууль (УИХ-ын 2002 оны 6 сарын 7-ны өдрийн 56-р тогтоол)**
 - Хуулийн 3-р зүйлд газар ашиглалттай холбоотой эрхийг тодорхойлсон бөгөөд тэдгээр нь газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх юм.
 - Тус хуулийн 3.1.2-т Монгол улсын иргэнд гэр бүлийн болон аж ахуйн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлнэ гэж заасан. Өмчлөх газрын хэмжээ нь засаг захиргааны нэгжээс шалтгаалан өөр өөр байна (нийслэл хотод 0.007 га, аймгийн төвд 0.35 га, сумын төвд 0.5 га). Өмчлөлийн эрхийг Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд заасны дагуу олгоно.
 - Хуулийн 3.1.3-т “газар эзэмших” эрхийг тодорхойлохдоо газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлэх бөгөөд энэхүү гэрээний хугацаа 15-60 жил байна гэж заасан.
 - Хуулийн 3.1.4-т “газар ашиглах” эрхийг тодорхойлж, хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэх явдал бөгөөд газар ашиглах гэрээ нь 5 жилийн хугацаатай байх ба нэг удаа дахин 5 жилээр сунгаж болно гэж заасан.
 - Тус хуулийн 6-р зүйлд дараах төрлийн газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана гэж заасан. Үүнд:
 - Бэлчээр, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газар
 - Хот, тосгон, бусад суурины нийтийн эдэлбэрийн газар
 - Зам, шугам сүлжээний газар
 - Ойн сан бүхий газар
 - Усны сан бүхий газар

³ Энэ хэсэгт Оюу Толгойн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд (2015) тусгагдсан мэдээллийг ашигласан www.ot.mn

- Хуулийн 29-р зүйлд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0.07 га-гаас (700 м²) илүүгүй байна гэдгийг хуульчилж зааж өгсөн.
- Энэ хуулийн 50-р зүйлд газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцна хэмээн хуульчилсан.
- Хуулийн 52-р зүйлд зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ гэж заасан.
- **Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006 оны 12 сарын 15)**

Монгол улсын иргэн засаг захиргааны нэгжээс гаргасан дүрэм журам, шийдвэрийг санаатайгаар зөрчсөн тохиолдолд энэхүү хуулийн дагуу шийтгэл оногдуулна.
- **Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002 оны 6 сарын 27)**
 - Тус хуулийн 7-р зүйлд, Монгол улсын иргэнд гэр бүлийн зориулалтаар өмчлүүлэх газар нь түүний байршил, зориулалтаас хамааран дор дурдсан хэжээтэй байна гэж заасан. Үүнд:
 - Нийслэлд 0.07 га хүртэл
 - Аймгийн төв болон Дархан, Эрдэнэт хотуудад 0.35 га хүртэл
 - Сумын төв, тосгонд 0.5 хүртэл га
 - Энэ хуулийн 34 ба 37 зүйлд иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах ажлыг хэрхэн гүйцэтгэх талаар заасан. Хуулийн хамгийн чухал заалт бол 37.2 бөгөөд энд иргэний өмчийн газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргахаас нэг жилээс доошгүй хугацааны өмнө газар өмчлөгчид бичгээр мэдэгдэнэ гэсэн заалт юм.

Тайлбар

Хэдийгээр Газрын тухай хууль болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд иргэний өмчийн газрыг эргүүлэн авах тохиолдолд газрыг зах зээлийн үнээр тооцож нөхөн олговор өгнө гэж заасан боловч бодит амьдрал дээр газрын үнийг Засгийн газраас тогтоодог. Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 103-р тогтоолоор хувийн өмчийн 1 м² газрын үнийг 13000 төгрөгөөр тогтоосон. Барилга байшинг үнэлэхдээ ЗГ-ын 2006 оны 111-р тогтоол болон Олон улсын үнэлгээний стандартыг баримталдаг. Бусад төрлийн хохирлын үнэлгээг зохицуулах хууль тогтоомж байдаггүй⁴. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиар өвөлжөө, хаваржааны газрын ашиглалттай холбоотой гэрээг сумын Засаг дарга малчидтай хийхээр зохицуулсан байдаг. Гэсэн хэдий ч энэ эрх тухайн бэлчээрийн талбайг бүхэлд нь хамарч хэрэгждэггүй. Өвөлжөө, хаваржааг эзэмших эрх 60 жилийн хугацаатай байдаг. Бэлчээр ашиглалтын уламжлал нь тухайн өвөлжөө, хаваржааг эзэмших эрх хэнд олгогдоход нөлөөлдөг бөгөөд шинээр ирсэн малчид сул чөлөөтэй газарт өөрийн өвөлжөө, хаваржааг барьж, тэрхүү газрыг эзэмших хүсэлтээ гаргах боломжтой.

⁴ Дэлхийн банк (2016) Land Acquisition and Resettlement Legal Framework Terms of Reference, <http://documents.worldbank.org/curated/en/585621468277494387/text/RP11910v20P1220nnexes0003100802011.txt>

Одоогийн байдлаар өвөлжөө, хаваржаа бүгд албан ёсоор бүртгэгдэж, зөвшөөрөл аваагүй хэдий ч энэ нь эзэмшлийн зөвшөөрөл авсан бусад малчдын эрхэд муугаар нөлөөлж буй зүйл байхгүй байна.

Дүгнэлт:

- Газрыг өмчлөх, эзэмших, ашиглах эрх нь Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн.
- Малчдын хувьд, өвөлжөөгөө (мөн хаваржаа) эзэмших эрхтэй бөгөөд тэрээр албан ёсоор бүртгүүлж, зөвшөөрөл авах боломжтой.
- Бэлчээрийг бүх нийтээр ашиглах ёстой.
- Хуулийн ерөнхий заалтаас өөрөөр нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговрын талаар тусгайлан заасан зүйл байхгүй. Эдгээр асуудлыг улсын, эсвэл олон нийтийн байгууллага гарган ирж, шийдвэрлэдэг.

2.2 Олон улсын шаардлага

2.2.1 Оршил

ССП төслийг санхүүжүүлэгч байгууллагууд нь Norddeutsche Landesbank Girozentrale (Nord LB), Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ), Экспорт кредит фонден (ЭКФ), Хөгжиж буй орнуудад зориулсан хөрөнгө оруулалтын сан (ХБОЗХОС) болон Финфанд (ФФ) юм. Эдгээр байгууллагууд нь тус бүр өөрийн гэсэн байгаль орчин, нийгмийн стандарттай бөгөөд нүүлгэн шилжүүлэлтийн тухайд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт бол Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт 5 (2012) юм. Экспорт кредит фонден, Экваторын банкны болон Экваторын зарчмууд ч мөн энэхүү төслийн үйл ажиллагаанд хамаатай. Эдгээрийн талаар доор дэлгэрүүлэн өгүүлэв:

2.2.2 Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт

ОУСК нь өөрийн үйлчлүүлэгчдийн нийгэм, байгаль орчны эрсдэлийг удирдах үүрэг хариуцлагыг найман бүлэг Гүйцэтгэлийн стандартаар тодорхойлж өгсөн байдаг. Эдгээр стандарт нь дэлхий дахинаа нийгэм, байгаль орчны удирдлагыг үнэлэх гол шалгуур болдог бөгөөд Гүйцэтгэлийн стандарт 5 нь газар ашиглалт болон албадан нүүлгэн шилжүүлэлтийн асуудалд голлон чиглэгдсэн.

Гүйцэтгэлийн стандарт 5: Газар ашиглалт ба албадан нүүлгэн шилжүүлэлт – энэхүү стандарт нь дараах зорилгыг агуулдаг:

- Төслийн өөр хувилбарыг эрэлхийлэх замаар нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд багасгах
- Хүчээр албадан нүүлгэхээс зайлсхийх
- Газар ашиглалт, эсвэл газар ашиглалтад хязгаар тавьснаас үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг урьдчилан тооцож, түүнээс зайлхийх. Хэрэв зайлсхийх боломжгүй бол дараах арга замаар сөрөг нөлөөллийг бууруулах: 1) нүүлгэн шилжүүлэлтээс болж алдсан эд хөрөнгийн зардлыг тооцож, нөхөн төлбөр өгөх, 2) нүүлгэн шилжүүлэх ажлыг хийхдээ нөлөөлөлд өртсөн иргэдэд мэдэгдэж, харилцан санал солилцож, хангалттай мэдээллээр хангах
- Нүүлгэн шилжүүлсэн иргэдийн амьжиргаа болон амьдралын чанарыг өмнөх байдалд нь эргүүлэн оруулах, улам сайжруулах
- Нөлөөлөлд өртсөн иргэдийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлж, шаардлагатай орон байраар хангах замаар тэдний амьдралын нөхцөлийг сайжруулах

Түүнчлэн дараах нэмэлт шаардлагыг тавьдаг. Үүнд:

- Нөхөн төлбөрийн стандарт нь нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн бүх хүнд хамаарах бөгөөд ил тод байна. Нүүлгэн шилжүүлсэн иргэдийн амьжиргаа газар ашиглалт дээр суурилсан, эсвэл газрыг хамтаараа эзэмшиж, ашигладаг бол тэдэнд газар дээр суурилсан нөхөн төлбөрийг санал болгоно. Төсөл нь нөлөөлөлд өртсөн иргэдэд нөхөн төлбөрийг төлсний дараа тэдний газар болон холбогдох өмч хөрөнгийг авна.
- Нөлөөлөлд өртсөн айл өрхүүд төслийн санал, гомдол, хүсэлт барагдуулах механизмтай танилцах ёстой.
- Бодит нүүлгэн шилжүүлэлт шаардлагатай нөхцөлд Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг (НШТ) боловсруулах шаардлагатай.
- Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэд гэдэгт тухайн улсын хуулийн дагуу газар ашиглах албан ёсны зөвшөөрөлтэй, мөн ийм зөвшөөрөлгүй ч энэхүү эрхийг эдлэх эрх нээлттэй хүмүүс багтана.
- Нөхөн төлбөрийн асуудлыг шийдэхдээ бэлэн мөнгөний хэлбэрийг мөн авч үзнэ. Нөхөн төлбөрийг бэлэн мөнгөөр хийж буй тохиолдолд тухайн иргэний алдсан газар болон бусад эд хөрөнгийг орон нутгийн зах зээлийн ханшаар тооцон үнэлж олгоно.
- Тасалбар болгох өдрийг тогтоож, албан ёсоор мэдэгдсэнээс хойш төсөл хэрэгжих талбайд хүчээр нэвтрэн нутагласан хүмүүст төсөл нөхөн төлбөр олгохгүй.
- Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд (эд хөрөнгөө алдсан, эсвэл эд хөрөнгөндөө хүрэх боломжгүй болсон) өртсөн хүмүүст учирсан хохирлыг бүрэн төлнө.

2.2.3 Экваторын зарчмууд

Экваторын зарчмын санхүүгийн байгууллагууд (ЭЗСБ) санхүүгийн дэмжлэг үзүүлж буй Төслүүдийг нийгмийн хариуцлагатай, байгаль орчны ухаалаг удирдлагатай байлгах үүднээс Экваторын зарчмуудыг боловсруулсан байна. 2013 онд нийт 10 зарчмыг агуулсан Экваторын зарчмууд III-г боловсруулан гаргасан.

Монгол улсад хэрэгжиж буй төслүүдийг ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартын дагуу үнэлэх шаардлагатайгаас гадна төслийн нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд дараах Экваторын зарчмуудыг мөн авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- Зарчим 5: Сонирхогч талуудын оролцоо:
 - Байгаль орчин, нийгэмд нэлээд ноцтой сөрөг нөлөөтэй төслүүдийн хувьд олон нийтийн хэлэлцүүлгийг урьдаас зарлан зохион байгуулж, тэдний оролцоог хангана.
 - Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл их, эрсдэл өндөртэй төслүүдийн хувьд, Төслийн барилгын үе шат эхлэхээс өмнө, үнэлгээний ажлын явцтай хамт төслийн мэдээллийг олон нийтэд хүргэх ба мэдээлэл түгээх ажлыг цаашид тогтмол явуулна.
- Зарчим 6: Гомдол, санал, хүсэлт барагдуулах механизм:
 - ЭЗСБ нь төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах, мөн шийдвэрлэх механизмыг Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцооны (БОНУТ) нэг хэсэг болгон боловсруулахыг төслөөс шаардана.

2.2.4 Европын хөрөнгө оруулалтын банк

ЕХОБ нь Байгаль орчин ба нийгмийн 10 бүлэг стандартыг боловсруулсан. Тэдгээрээс нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой стандартуудыг нэгтгэн дурдвал:

- Стандарт 1: Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө, учрах эрсдэлийг үнэлэх, удирдах.
 - Энэ стандарт нь ЕХОБ-ны төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө, учрах эрсдэлийг үнэлэх, удирдах, хянах процесст төслийг

санаачлага ямар үүрэг хариуцлагатай болохыг тодорхойлох зорилготой. Тус стандартын шаардлагын дагуу төсөл нь байгаль орчин, нийгмийн үр ашигтай удирдлага, тайлангийн системийг боловсруулж, цаашид тасралтгүй сайжруулан хөгжүүлэх ёстой. Энэхүү стандартад сонирхогч талуудын оролцоог хангах, төслийн туршид тэднийг мэдээллээр хангах шаардлагууд мөн багтсан болно.

- Стандарт 6: Албадан нүүлгэн шилжүүлэлт.
 - Заримдаа ЕХОБ-ны зарим төслүүдийн хувьд нутгийн иргэдийг газар ашиглах эрхийг түр хугацаагаар хязгаарлаж, оршин суугаа газраас нь түр зуур нүүлгэн шилжүүлэх шаардлага гардаг. Стандарт 6 нь төслийн нөлөөнд өртсөн бүх хүн ам, суурин газрын өмч хөрөнгө, тохирох байр сууц, амьдрах стандартыг нь хүндлэн хамгаалах явдлыг гол үндэс болгон баримталдаг. Газар ашиглалтыг хязгаарлах, өмч хөрөнгөө алдсанаас үүсэх сөрөг нөлөөг багасгахыг эрмэлздэг. Түүнчлэн нөлөөнд өртсөн хүмүүсийн амьдралыг дээшлүүлэх, дор хаяж өмнөх аж амьдрал, амьралын стандартыг нь сэргээж өгөх, мөн учирсан алдагдалтай нь тэнцэх нөхөн олговрыг өгөхийг зорино.
- Стандарт 7: Эмзэг бүлгийн иргэдийн эрх ба ашиг сонирхол.
 - ЕХОБ нь төслийн нөлөөнд өртсөн эмзэг бүлгийнхнийг хамгаалахын зэрэгцээ ЕХОБ-ны үйл ажиллагаанаас зохих ёсоор үр өгөөж хүртээхийг зорьдог. Нутгийн уугуул иргэд болон эмзэг бүлгийнхний эрх, нэр хүнд, хүсэл мөрөөдөл, соёл заншил болон амьдралын хэв маягт хүндэтгэлтэй хандахыг шаарддаг. Нутгийн уугуул иргэдтэй эртнээс уулзаж ярилцан, төслийн талаар танилцуулна.

2.3 Монгол улсын хууль тогтоомж ба ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартын ялгаа⁵

Хүснэгт 2.1-т Монголын улсын хууль болон ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартуудын ялгаа тоймлон харуулав.

Хүснэгт 2.1 Монгол улсын хууль тогтоомж ба ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартын ялгаа

Сэдэв / Баримт	Монгол улсын хууль	ОУСК-ийн шаардлага	Ялгаа буюу орхигдлыг арилгах арга зам
Албадан хураах	Албадан хураах арга хэмжээг зөвхөн төр болон төрийн байгууллага хариуцна. Хувийн хэвшлийн байгууллагуудад ийм эрх байхгүй.	Албадан хураах арга хэмжээг хамгийн эцсийн арга хэрэгсэл гэж үзнэ.	Орхигдол байхгүй
Харилцан зөвшилцсөний үндсэн дээр газрыг авах	Монгол улсын Иргэний хуульд газрыг гэрээний үндсэн дээр шилжүүлэх харилцааг хуулиар зохицуулдаг.	Харилцан зөвшилцсөний үндсэн дээр оршин суух газрыг нь тогтоох	Орхигдол байхгүй
Нөхөн төлбөр авах эрх	Зөвхөн газар өмчлөх, эзэмших, ашиглах албан ёсны зөвшөөрөлтэй хүнд энэ эрх олгогдоно.	Хууль ёсны болон албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн эрхтэй, аль эсвэл хууль ёсны эрх	Газар өмчлөх, эзэмших, ашиглах зөвшөөрлийг албан ёсоор аваагүй иргэдэд энэ эрхийг олгох

⁵ Оюу Толгойн (2015) Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнөөс авч ашиглав www.ot.mn

		аваагүй ч тухайн газар болон эд хогшлыг ашиглаж, мөн тэнд амьдарч буй хүмүүст энэ эрх өгөгдөнө.	шаардлагатай.
Тасалбар болгох өдөр	Тодорхой зохицуулалт байхгүй	Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн тоог нарийн тогтоож, тасалбар болгох өдрийг тогтон тэдэнд мэдэгдэнэ. Тасалбар болгох өдрийн дараа төслийн талбайд хүчээр дайран орж нутагласан хүмүүс нөхөн олговор авах эрхгүй	Нөхөн төлбөр авах эрх бүхий хүмүүст зориулан тасалбар болгох өдрийг тогтоох хэрэгтэй.
Нөхөн төлбөр	Газар болон аливаа барилга байгууламжид оноох нөхөн төлбөрийн хэмжээг төр тогтоох ба энэ нь ихэнхдээ үнийг багасгаж тооцсон байдаг.	Нөхөн төлбөрийн хэмжээ нь нөлөөлөлд өртсөн газар болон эд хөрөнгийн үнэ өртгийг бүрэн багтаасан байна.	Нөхөн төлбөр нь өртсөн эд хөрөнгийн үнийг бүхэлд нь багтаасан байх ёстой. Нөхөн олговор хамгийн түрүүний сонголт байх учиртай.
Нийтээр ашигладаг нөөц	Бэлчээр нь бүх нийтээр ашигладаг нөөц гэж үздэг тул түүнд нөхөн төлбөр олгох ёсгүй.	Газар ашиглалт болон бусад эд хөрөнгөтэй холбоотой амьжиргаанд учирсан нөлөөлөлд нөхөн төлбөр олгох ёстой.	Зуслангийн бэлчээрийг түр хугацаанд ашиглах боломжгүй болсны төлөө малчид нөхөн төлбөр авах эрхтэй.
Амьжиргааг сэргээх	Тодорхой зохицуулалт байхгүй	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн айл өрхийн амьжиргааг нөхөн сэргээх, дээшлүүлэх арга хэмжээг авах шаардлагатай.	Амьжиргааг нөхөн сэргээх арга хэмжээг нөхөн төлбөр авах эрх бүхий хүмүүст чиглүүлэх учиртай.
Эмзэг бүлгийн хүмүүс	Тэдэнд зориулсан тусгай зохицуулалт байхгүй	Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн эмзэг бүлгийн хүмүүсийн амьжиргааг бүрэн дүүрэн дээшлүүлэх хэмжээний нөхөн төлбөр олгоно.	Нөлөөлөлд өртсөн эмзэг бүлгийг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд тэдэнд зориулсан нэмэлт арга хэмжээг тогтоох
Гомдол, санал барагдуулах механизм	Газрын тухай хуульд газрын талаарх аливаа маргааныг засаг захиргааны нэгж шийдэх ба хэрэв үүгээр шийдэгдэхээргүй бол шүүхээр шийднэ гэж заасан (Зүйл 60)	Нөлөөлөлд өртсөн хүмүүст нээлттэй, ашиглахад тохиромжтой гомдол, санал барагдуулах механизм боловсруулахыг шаарддаг.	Нөлөөлөлд өртсөн айл өрх өөрсдийн санал, хүсэлт, гомдлыг илэрхийлэх боломжтой байх үүднээс гомдол, санал барагдуулах механизмыг боловсруулах (Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөнд).

Мэдээлэл түгээх, олон нийтийн хэлэлцүүлэг уулзалт	Монгол улсын газар өмчлүүлэх тухай хуульд газар өмчлөх хууль ёсны зөвшөөрөлтэй хүний газрыг авах шаардлага гарвал энэ тухай нэг жилийн өмнө мэдэгдэнэ гэж зааснаас өөрөөр мэдээлэл хүргэх, олон нийтийн хэлэлцүүлэг уулзалтын талаар тодорхой зохицуулалт байхгүй.	Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүст нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн төлбөрийн талаар бүрэн дүүрэн мэдээлэл өгч, боломжит хувилбарын талаар сайтар зөвлөлдөнө. Бодит нүүлгэн шилжүүлэлт хийгдэх шаардлагатай нөхцөлд НШТ-г тэдэнд танилцуулна.	НШТ-г боловсруулж, танилцуулна.
Мониторинг ба үнэлгээ	Орон нутгийн засаг захиргаа ба иргэдийн нөхөрлөлүүдийн үүрэг	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, үнэлэх үйл явцыг тодорхойлсон байх.	Мониторинг, үнэлгээний үйл явцыг НШТ-нд тодорхойлох.

3 НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.1 Мэдээллийн эх сурвалж

Энэ хэсэг дэх нийгэм-эдийн засгийн төлөв байдлын талаарх мэдээллийг дараах эх сурвалжуудаас авсан болно. Үүнд:

- Сайншанд салхин парк төсөлд хийсэн БОННУ (2015). Гүйцэтгэсэн байгууллага: Байгаль-Экологи ХХК
- 2016 оны 5 сард Тэкол ХХК-ны хийж гүйцэтгэсэн хээрийн судалгаа, айл өрхийн судалгаа⁶
- МоттМакДоналдс компанийн 2016 оны 6 сард хийсэн Байгаль орчин, нийгмийн иж бүрэн судалгаа
- 2016 оны 10 сард Тэкол ХХК ба Shared Resources компанийн хамтарсан хээрийн судалгаа, нөлөөлөлд өртсөн айл өрх болон засаг захиргааны төлөөлтэй хийсэн уулзалт ярилцлага
- 2016 оны 11 сарын 30-нд Тэкол ХХК болон ССП компанийн төлөөллүүд нөлөөлөлд өртсөн өрхийн гишүүдтэй ярилцаж, эд хогшлын бүртгэл хийсэн.

2016 оны 5 сард Тэкол ХХК-ий хийсэн өрхийн судалгаагаар төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй хүн амын нийгмийн төлөв байдлыг тодорхойлсон. Энэ судалгаа нь тухайн үед төслийн талбайд нутаглаж байсан малчин өрхүүд болон өмнөх судалгааны тайланд (тухайлбал, МоттМакДоналдс компанийн иж бүрэн судалгааны тайлан болон Байгаль-Экологи ХХК-ийн хийсэн БОННУ-ний тайлан) тухайн газарт нутаглаж, бэлчээр ашиглаж байсан хэмээн тэмдэглэгдсэн өрхүүдэд гол анхаарал хандуулсан. Малчдын нүүдлийн амьдралын хэв маяг, цаг агаар, бэлчээрийн төлөв байдлаас шалтгаалан зуслангийн байршил өөрчлөгдөж байдаг тул тухайн газар нутагладаг бүх малчдыг бүрэн тогтооход бэрхшээлтэй байсан хэдий ч нутгийн малчдаас нарийвчлан асууж лавласны дүнд харьцангуй бүрэн дүүрэн мэдээлэл олж авсан. Төсөл хэрэгжих талбайн орчимд бүтэн жилийн туршид нутаглан, бэлчээр ашигладаг 7 өрхийг тогтоосон. 2016 оны 5 сард эдгээр 7 айлын 4-тэй нь нүүр тулан уулзаж, 3-тай нь утсаар холбогдож ярилцсан. 2016 оны 10 сард дээрх өрхүүдтэй дахин уулзсан. Өвөлжөө нь төслийн нөлөөлд өртсөн өрхүүдтэй 2016 оны 11 сарын 30-нд (өвөлжөөнд буух хугацааг тасалбар болгох өдөр) дахиж уулзаж, эд хогшлын бүртгэл хийсэн.


3.2 Засаг захиргааны нэгж

Төслийн талбай нь Дорногов аймгийн Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын хилийн зааг нутагт байрлана. Дорноговь аймгийн газар нутгийн хэмжээ 109400 км² бөгөөд нийт 58612 (2010 оны хүн амын тооллогоор) хүн амтай (Монгол улс нийт хүн ам 3.1 сая). МОНСИС-ийн тайланд Дорноговь аймгийн хүн амын нягтшилыг 0.6/км² гэж тэмдэглэсэн байна⁷.

⁶Энэ судалгааны үеэр малчдын гэрээр очиж, уулзаж ярилцсан. Түүнчлэн, Дорноговь аймгийн Хөгжлийн бодлогын тасгийн даргатай (Олзбаярын Лутбаяр. Утас: 96621989. E-mail: kad_olloo@yahoo.com) уулзаж ярилцсан. Эдгээр уулзалт, ярилцлагаас олж авсан мэдээлэл дээр үндэслэн санал асуулгын хуудсыг шинэчлэн засварласан. Энэхүү засварыг хийсний дараа дээрх албан тушаалтан болон 3-р багийн дарга, малчин өрхүүдтэй хэд хэдэн удаа утсаар холбогдож, илүү нарийвчилсан мэдээллийг авсан.

⁷ <http://www.1212.mn/statHtml/statHtml.do>

Зураг 3.1 Алтанширээ, Сайншанд, Өргөн сумдын төв



3.3 Хүн амзүйн гол онцлог

Сайншанд хот нь Төслийн талбайд хамгийн ойр буюу баруун хойд зүгт 7 км зайд оршдог (Зураг 3.1). Сайншанд нь Дорноговь аймгийн төв бөгөөд нийт 58612 хүн амтай гэж тоологдсоноос 34000 нь байнгын оршин суух бүртгэлтэй, 24612 нь бүртгэлгүй оршин суугчид аж⁸. Хүснэгт 3.1-ээс харвал, Алтанширээ, Өргөн сумдын хүн ам харьцангуй цөөн байна.

Хүснэгт 3.1 Байнгын оршин суугчид⁹

Сум	2013	2014	2015
Сайншанд	22,011	22,666	23,191
Алтанширээ	1,297	1,286	1,262
Өргөн	1,921	1,904	1,889

Сум нь багт хуваагдах ба төслийн талбай нь Сайншанд сумын 3-р баг, Өргөн сумын 1-р баг буюу Сумын булаг багийн нутагт оршино. Сайншанд сумын 3-р багийн нийт талбай 29715 км², хүн ам 5369¹⁰. Өргөн сумын Сумын булаг багаас энэ талаарх мэдээлэл олдоогүй.

Төслийн талбай нь хөдөө хээр газарт байрлаж байгаа тул нөлөөлөлд өртөх магадлалтай хүмүүс нь малчид юм.

3.4 Монголын нүүдэлч малчдын амьдралын хэв маяг, онцлог¹¹

Монголын нүүдэлчин малчдын аж амьдрал нь энэ дэлхий дээр үлдэж хоцорсон цорын ганц нүүдэлчин соёл юм. Бэлчээрт түшиглэж амьдардаг нүүдэлчид нь жилийн дөрвөн улиралд бэлчээр

⁸ Сайншанд сумын 3-р багийн дарга, хатагтай Нарангэрэлээс авсан мэдээлэл, 2016 оны 10 сарын 4

⁹ МОНСИС (2016) <http://www.1212.mn/statHtml/statHtml.do>

¹⁰ Сайншанд сумын 3-р багийн дарга, хатагтай Нарангэрэлээс авсан мэдээлэл, 2016 оны 10 сарын 4

¹¹ Б.Сумъяа Монголын нүүдэлчин соёл, 2000

сэлгэн нүүдэллэдгээрээ ан ав, үр жимс түшиглэн амьдардаг хүмүүсээс ялгаатай. Нүүдэлчид тодорхой бэлчээр, усыг хэдэн зуун жилийн турш үе дамжин ашиглаж ирсэн түүхтэй. Энэ уламжлал өнөөг хүртэл хадгалагдсан хэвээр бөгөөд малчин айлууд уулын нөмөр нөөлөг газар өвөлжиж, урин цаг ирэхэд өвөлжөөнөөсөө тал газар руу нүүдэг. Орчин үед малчид зөвхөн өвөлжөө, хаваржааныхаа газрыг (0.35 га) албан ёсны зөвшөөрлийн гэрчилгээтэйгээр эзэмших эрхтэй (Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль 7.1) болсон бөгөөд тэрхүү газар дээрээ малын хашаа саравч, өөрсдийн гэрийг барин нутагладаг.

Малчид жилд хоёр удаа, хавар (гурван сард-цаг агаарын байдлаас шалтгаалан), мөн өвлийн эхэн сард (арваас арван нэгэн сард) нүүдэллэдэг. Мөн шаардлагатай үед бэлчээрийн гарц, усны нөөцийг даган нүүдэллэх явдал элбэг. Тухайлбал, өвлийн улиралд малчид отор нүүдэл хийж, өвлийг өнтэй давдаг. Өвөлжөөг уулын нөмөр, энгэр ээвэр газарт сонгож, малын дулаан хашаа саравч барьж бэлддэг.

Зуны дэлгэр цагт малчид өвсний соргог, усны тунгалагийг бараадан, сэрүүн задгай газар нутагладаг. Зуслангийн газрыг сонгох хамгийн чухал шалгуур нь бэлчээрийн гарц, уст цэгийн байршил байдаг. Өвөлжөөний газрыг хамгаалах зорилгоор өвөлжөөнд тохиромжтой газарт зуслангийн газар сонгохыг хориглодог.

Дорноговь аймгийн малчид малаас авах ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд ямаа, хонь, үхэр, адуу, тэмээ гэх өөр өөр төрлийн мал маллах сонирхолтой байдаг. Өвлийн улирлаас бусад үед бог мал (ямаа, хонь) зуншлагаас дунджаар 5 км-ийн дотор бэлчээрлэдэг бол бод мал 10 болон түүнээс хол зайд бэлчээрлэдэг.

1990-ээд оны эхээр Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа 1993 онд малыг малчдад хувьчилсан хэдий ч бэлчээр улсын өмч хэвээр үлдсэн. Малыг малчдад хувьчилснаас хойш мал маллагаатай холбоотой бүх асуудал малчдын өөрсдийнх нь үүрэг хариуцлага болж хувирсан. Энэ хугацаанд малын тоо толгой эрс өсөж, 1990 онд 22 сая байсан бол 2007 онд 40.3 сая болсон.¹²

Малчин өрхийн бүх гишүүд өдөр тутмын ажил үүргээ тэнцүү хуваан хийх ба аль нэгнээсээ илүү чухал ажил гэж байхгүй. Уламжлал ёсоор, эрчүүд адуу малаа адгуулахын зэрэгцээ эмээл, тоноглол, зэр зэвсэг бэлтгэдэг бол эмэгтэйчүүд үнээ мал саах, сүү цагаан идээ боловсруулах, хоол хүнс бэлтгэх, үр хүүхдээ өсгөх ажлыг амжуулдаг.

3.5 Нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхийн онцлог шинж

Нөлөөлөлд өртсөн иргэдийн нийгэм-эдийн засгийн онцлог шинжийг тодорхойлохын тулд тоон болон чанарын судалгааны аргыг ашигласан. Судалгааг өрхийн түвшинд хийсэн. Судалгаанд хамрагдсан хүмүүс бүгд (100 хувь) малчид байлаа. Судалгаанд ашигласан асуулгын хуудсыг Хавсралт А-гаас харна уу.

3.5.1 Нөлөөлөлд өртөж болзошгүй айл өрхийн хүн амзүйн онцлог

Монголын хөдөөгийн нэг айл дунджаар 6 ам бүлтэй байдаг. Судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан өрхүүд харьцангуй ам бүл цөөнтэй буюу дунджаар 2-3 гишүүнтэй байв. Хамгийн цөөн ам бүлтэй нь 1, хамгийн олон ам бүлтэй нь 5 хүнтэй өрх байлаа.

¹² Тоо баримтыг С.Жамсранжаваас (2009) Монголын бэлчээрийн тогтвортой менежмент: Малчдын бүлгийн институцын үүрэг, http://www.unulrt.is/static/fellows/document/jamsranjav_c.pdf

3.5.2 Нас, хүйсийн байдал

Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй 7 өрхийн гишүүдийн нас, хүйсийн бүтцийг Хүснэгт 3.2-т нэгтгэн харуулав. Хүснэгтээс харахад, нийт гишүүдийн бараг тал хувийг дунд эргэм насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс эзэлж байгаа бол 26 % нь 15-аас доош насны хүүхдүүд байна. Эндээс аваад үзвэл, судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн дөрөвний нэг нь хөдөлмөрийн насанд хүрээгүй хүүхдүүд байна. Өрхийн тэргүүний дундаж нас 43.7, тэдний хамгийн залуу нь 29, хамгийн ахмад нь 60 настай.

Хүснэгт 3.2 Судалгаанд хамрагдсан 7 өрхийн гишүүдийн нас, хүйсийн бүтэц

Өрх	Хүйс	Насны бүлэг						Бүгд
		0-5	6-14	15-25	26-35	36-64	65+	
	Нийт эрэгтэй	1	1	2	1	5	0	10
	Нийт эмэгтэй	2	2	2	2	5	0	13
	БҮГД	3	3	4	3	10	0	23
	БҮГД %	13.04	13.04	17.4	13.04	43.5	0	100

Эх үүсвэр: Тэкол ХХК, 2016

Үүнээс гадна, судалгаанд хамрагдсан өрхүүдэд эрэгтэйчүүдийн эзлэх хувь их буюу эрэгтэй, эмэгтэй хүний харьцаа 1.3:1 байна.

3.5.3 Боловсрол

Боловсрол нь судалгаанд хамрагдсан өрхүүдийн нийгэм-эдийн засгийн байдлыг илтгэн харуулаад зогсохгүй, мөн тэдний ажил хийх боломж чадавхи, аливаа өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг харуулдаг.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн (6-гаас дээш насны)¹³ тал орчим хувь нь ерөнхий боловсролын дунд сургууль (бага болон дунд анги дүүргэсэн) төгсгөсөн бөгөөд тэдний 35.3 хувь нь эмэгтэйчүүд байгааг судалгаанаас харж болно.

Table 3 3 Судалгаанд хамрагдсан долоон өрх гишүүдийн боловсролын түвшин (хүйсээр)

Боловсролын түвшин	Хүйс	Бүгд
Бага анги	Эмэгтэй	0
	Эрэгтэй	3
Дунд анги	Эмэгтэй	3
	Эрэгтэй	3
Ахлах анги	Эмэгтэй	2
	Эрэгтэй	6
Их сургууль	Эмэгтэй	1
	Эрэгтэй	1
Бүгд		19

Эх сурвалж: Тэкол ХХК, 2016

3.5.4 Ажил эрхлэлт

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн насан хүрсэн хүмүүсийн ихэнх нь мал малладаг. Энэ нь цалин хөлсгүй ажил юм. Хоёр эмэгтэй (нийт эмэгтэйчүүдийн 40 хувь) Сайншанд хотод ажилладаг.

¹³ 6 нас буюу сургуулийн нас хүрээгүй 3 хүүхэд бий.

Хүснэгт 3.4 Өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдал

Ажил эрхлэлт	Бүгд
Малчин	10
Ажилтан	3
Оюутан	7
Сургуулийн насанд хүрээгүй хүүхэд	3
Өрхийн нийт гишүүд	23

Малчид бүхэл өдрийн туршид мал хариулах, сүү сааль авах, хонь хяргах, ямаа самнах гэх мэт ажлуудыг хийж, авсан түүхий эдээрээ эсгий, хувцас хийж, бяслаг, хурууд гэх мэт цагаан идээ бэлтгэдэг.

3.5.5 Монгол гэрийн онцлог

Малчид монголын уламжлалт эсгий гэрт амьдардаг. Гэр бол хэдэн зуун жилийн турш хатуу ширүүн уур амьсгалын дунд нүүдэллэн амьдарч ирсэн монголчуудын уламжлалт сууц юм. Гэр нь хураах, нүүхэд хялбар модон хэсгүүд буюу хана, тооно, унь, багана, хаалганаас бүрдэнэ. Гэрийн нийт жин 150-300 кг бөгөөд ойролцоогоор 2 цагийн дотор буулгаж, эргүүлэн барих боломжтой (Зураг 3.2).



Зураг 3.2 Уламжлалт Монгол гэр

Судалгаанд хамрагдсан айлуудын дийлэнх нь гар утас, мотоциклтой бол цөөн зарим нь тавган антен, зурагт, авомашинтай.

Хүснэгт 3.5 Өрхүүдийн ахуйн хэрэглээний техник хэрэгсэл

Өрх	ТВ	Тавган антен	Ачааны машин	Мотоцикл	Бага оврын цахилгаан үүсгүүр
Нийт 7 өрх	4	4	2	5	4

Эх сурвалж: Тэкол ХХК, 2016

3.5.6 Усны эх үүсвэр

Говь цөлийн бүс нь маш хуурай учраас зуслан болон өвөлжөөний газрыг сонгоход усны эх үүсвэр байгаа эсэх маш чухал шалгуур болдог. Судалгаанд хамрагдсан бүх өрх төслийн талбайгаас урагш байрлах (Зураг 3.3) гар худгаас ус авдаг. Үүнээс гадна, төслийн талбайгаас зүүн тийш өөр нэг гар худаг байдаг гэх боловч байршил нь тодорхой биш байв. Гар худгийг малчид өөрсдөө ухаж, дундаа хэрэглэдэг (Монголын хуулийн дагуу). Гар худгууд нь мал услахад тохиромжтой боловч ундны усны чанарыг тэр бүр хангаж чаддаггүй.

Зураг 3.3 Төслийн талбайн ойролцоох усны эх үсвэрүүд



Түүнчлэн гүний худгууд байх агаад тухайлбал, төслийн талбайн урд талд хувь хүний гаргасан шинэ, гүний худаг бий (Зураг 3.3-ыг харна уу).

3.6 Судалгаанд хамрагдсан өрхүүдийн эдийн засгийн байдал

Судалгаанд хамрагдсан 7 өрхийн амьжиргааны гол хэрэгсэл нь мал аж ахуй юм. Гэхдээ гурван өрх цалин хөлс, хүүхдийн мөнгө гэсэн санхүүгийн нэмэлт эх үүсвэртэй байна¹⁴.

Малчдын амьжиргаа нь малын тоо толгойгоос шууд хамаарна. Судалгаанд хамрагдсан өрхийн малын тоо толгойг аваад үзвэл, харьцангуй ялгаатай байх агаад 30-1000 малтай өрхүүд байна. Малын бүтцийн хувьд, ямаа голлох ба хонь, үхэр, адуу, тэмээ өсгөдөг. Өрхүүдийн малын төрөл, тоо толгойг Хүснэгт 3.6-д харуулав.

Хүснэгт 3.6 Судалгаанд хамрагдсан өрхүүдийн малын тоо толгой

	Мал					Бүгд
	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	
Нийт	637	1027	35	220	12	1931

Эх сурвалж: Тэкол ХХК, 2016

Малчидтай уулзаж ярилцахаас гадна Сайншанд сумын 3-р багийн засаг даргын газраас дараах мэдээллийг авсан. Үүнд: 2016 онд тус багт нийт 35000 мал тоологдсоноос, тэмээ 700, адуу 2240,

¹⁴ Хүүхдийн мөнгө-18 нас хүрээгүй бүх хүүхдүүдэд ямар нэг тодорхой нөхцөл заалгүй, сар бүр өгдөг 20 000 төг ($\approx$ 10.50 ам.дол).

үхэр 1300, хонь 14418, ямаа 16000 байжээ. Мөн оны байдлаар 3-р багт бүртгэлтэй малчдын тоо 73, харин мал бүхий өрхийн тоо 36 байсан байна. Тус багийн Засаг даргын үзэж буйгаар, багийн бүртгэлтэй малчдын дөнгөж 40 гаруй хувь нь л Сайншанд сумын ойр орчимд нутагладаг ажээ. Өргөн сумын 1-р баг буюу Сумын булаг багийн хувьд малын тоо толгой, малчдын талаар тодорхой мэдээлэл гаргаж өгөх боломжгүй байлаа. Сумын хэмжээнд аваад үзвэл, 2016 оны байдлаар тус суманд 64 малчин, 40000 тоо толгой мал бүртгэгджээ.

Малчид малын боловсруулаагүй түүхий эд зарж борлуулах замаар амьжиргаагаа авч явдаг бөгөөд түүхий эдийн үнэ ханш түүний чанараас шалтгаалан өөрчлөгдөж байдаг.

Судалгаанд хамрагдсан өрхүүдийн малаас олох орлого нь 150000 төг-өөс 7000000 төг хүртэл байх агаад дунджаар 3000000 төг байна. Энэ мэдээллийг Дорноговь аймгийн засаг захиргааны нэгжээс авсан болно.


Зураг 3.4-т судалгаанд хамрагдсан өрхүүдийн зуслан болон өвөлжөөг дүрслэн харуулав.



1. 1-р өрхийн өвөлжөө



2. 2-р өрхийн өвөлжөө



3. 7-р өрхийн өвөлжөөний газар



4. 4-р өрхийн өвөлжөө




5. 3-р өрхийн зуслан



6. 6-р өрхийн зуслан



7. 4-р өрхийн зуслан



8. Төслийн талбайн ойролцоох гар худаг

Зураг 3.4 Судалгаанд хамрагдсан өрхүүдийн зуслан, өвөлжөөний зураг

4 ТӨСЛИЙН ГАЗРЫН НӨЛӨӨЛӨЛ

ССП төслийн нийт талбай 486.6 га газрыг хамрах бөгөөд тухайн төслөөс газарт үзүүлэх нөлөөллийг үнэлэхийн тулд СЦҮ болон хамгийн ойр орших орон байрын хооронд байвал зохих аюулгүйн зайг/бүс тодорхойлох шаардлагатай. Энэ тохиолдолд орон байр гэдэгт малчдын өвөлжөөг ойлгоно.

4.1 Аюулгүйн зай/бүс

Төсөл хэрэгжих талбайд учрах бодит дарамтыг тодорхойлохын зэрэгцээ ССП төслийн аюулгүйн зайг/бүсийг тогтоох шаардлагатай юм. Аюулгүйн зай/бүс гэдэг нь СЦҮ болон түүний орчим орших аливаа орон байрын хооронд аюулгүй байх хамгийн ойр зайг хэлэх ба салхин цахилгаан станц үйл ажиллагаа явуулах бүх хугацааны туршид энэ зайг мөрдлөг болгоно. Ард иргэдэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор энэ зайг тогтоохдоо дараах гурван хүчин зүйлийг харгалзаж үзнэ. Үүнд:

- Дуу чимээ;
- Сэнсний далавч унах, түүнээс цас, мөс шидэгдэх эрсдэл;
- Сүүдэрлэлт;

4.1.1 Дуу чимээ

ОУСК-ийн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ерөнхий зөвлөмжид (2007) орон сууцанд зөвшөөрөгдөх дуу чимээний стандартыг дараах байдлаар тогтоосон байдаг:

- Өдрийн цагт - 55 децибелл
- Шөнийн цагт – 45 децибелл

Вестасын (Сайншандын салхин цахилгаан станцад ашиглагдах СЦҮ-ийг үйлдвэрлэгч) өгсөн мэдээлэл дээр үндэслэн тооцоход СЦҮ-ээс 500-600 м хүртэлх зайд 35-40 децибеллийн дуу чимээ тархахаар байна. Салхин цахилгаан станц 24 цагийн турш үйл ажиллагаа явуулах учраас шөнийн цагийн дуу чимээний хязгаарыг мөн авч үзэх хэрэгтэй бөгөөд энэ цагийн дуу чимээний дээд хязгаар болох 45 децибеллээс хэтрэхгүй дуу чимээ хүрэх хамгийн бага зай 500 м байна.

4.1.2 Сэнсний далавч унах, түүнээс цас, мөс шидэгдэх эрсдэл

Сэнсний эргэлдэх төхөөрөмж буюу моторын доголдлоос шалтгаалан сэнсний далавч юмуу түүний эд анги шидэгдэж, ойр орчмын хүмүүст аюул учруулах эрсдэлтэй. Хүйтний улиралд трубины сэнсэн дээр тогтож дагтаршсан цас сэнсний эргэлтээр шидэгдэх, эсвэл сул зогсолтын үед унах боломжтой¹⁵. Аюулгүйн бүсийн хэмжээг тогтоохдоо салхин трубины өндрийг (цамхаг+сэнсний радиус) 1.5-аар үржүүлж олохыг ОУСК зөвлөдөг ба тухайн агентлагаас шалтгаалан энэ зай өөр өөр гардаг¹⁶. Тухайлбал, Олон улсын эрчим хүчний агентлаг (ОУЭХА) аюулгүйн бүсийг тооцохдоо цамхгийн өндөр дээр сэнсний диаметрийг нэмээд (цамхаг+сэнсний диаметр) гарсан нийт өндрийг 1.5-аар үржүүлдэг¹⁷. ОУЭХА-ийн ашигладаг энэ томъёог VTT мөн санал болгодог¹⁸. Олон нийтийн аюулгүй байдлыг хангахын тулд Сайншанд салхин цахилгаан станц ч мөн аюулгүйн бүсийг тогтоосон. Уг төсөл нь Вестасын СЦҮ-ийг ашиглах бөгөөд түүний цамхагийн өндөр 95 м, сэнсний диаметр 110 м юм. Эндээс аюулгүйн бүсийг тооцвол 307.5 м гарч буй бөгөөд энэ нь сэнсний далавч/цас, мөсний шидэгдлээс хамгаалах хамгийн бага зай юм.

Салхин трубин зогсолт хийж байх үед түүн дээр тогтсон цас, мөс унах аюулаас сэргийлэх аюулгүйн бүсийн хамгийн ойр зайг дараах томъёогоор тооцоолсон. Үүнд:

$$d = \sqrt{(D/2 + H)}$$

15

¹⁵ ОУСК (2015) Салхин цахилгаан станцын Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зөвлөмж, хуудас 17

¹⁶ ОУСК (2015) Салхин цахилгаан станцын Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зөвлөмж, хуудас 17

¹⁷ ОУЭХА (2016) ОУЭХА Салхи, зорилт 19 – Хүйтэн уур амьсгалд тохирсон салхин эрчим хүч үйлдвэрлэлийн технологи

¹⁸ VTT (2010) Хүйтэн уур амьсгалтай газар хэрэгжих салхин эрчим хүчний төслүүдэд зориулсан зөвлөмж

Энд:

d = мөс унах хамгийн алсын зай (м)

v = трубины цамхаг орчмын салхины хурд (м/с)

D = ротор/сэнсний диаметр

H = цамхагийн өндөр

Сайншанд салхин цахилгаан станцад трубины цамхаг орчимд салхины хурд 7.6 м/с байна гэж үзэж буй бөгөөд энэ тохиолдолд дээрх хэмжигдэхүүнүүдийг харгалзан тооцвол трубины зогсолтын үед сэнснээс цас, мөс унах хамгийн алсын зай 76 м байна.

4.1.3 Сэнсний сүүдэрлэлт

Нар салхин трубины араар өнгөрөх үед сүүдэрлэх бөгөөд ийм сүүдэрлэлтийн талаар баримталдаг олон улсын стандарт байхгүй тул ОУСК-аас сүүдэрлэлтийн үргэлжлэх хугацаа жилд 30 цаг, өдөрт 30 минутаас хэтрэхгүй байхыг санал болгодог¹⁹. Сүүдэрлэлтийн нөлөөллийг Зураг 4.1-т дүрслэн харуулав. Хар улаан өнгөөр тэмдэглэсэн арзгар шугамаар бүтэн жилд тохиох 30 цагийн сүүдэрлэлтийг дүрсэлсэн. Дараах хоёр шалтгааны улмаас энэ загварыг хамгийн боломжтой гэж үзэж байна:

- Сайншандын СЦҮ-үүд нь хойноосоо урагш намссан тэгш өндөрлөг дээр байрлана. Тиймээс байршлын энэ онцлогоос шалтгаалан төслийн талбайгаас урагшлах тусам сүүдэрлэлтийн нөлөө буурна гэж дүгнэж болохоор байна.
- Энэ загвараас харахад, тухайн газар нутагладаг өрхүүд жилийн туршид сүүдэрлэлтийн нөлөөнд өртөхөөр харагдаж байгаа хэдий ч малчид жилд зөвхөн 5 сарын хугацаагаар л өвөлжөөндөө байдаг.

Дээр дурдсан шалтгаанууд болон сүүдэрлэлтийн загвар дээр үндэслэн дүгнэхэд, тус төслийн хувьд сүүдэрлэлтийн нөлөөлөлтэй холбоотой аюулгүйн бүс тусгайлан тогтоогдоогүй. Харин, төслийн талбайн ойролцоо байрлах өвөлжөөнүүд дотор 30 цаг/жил-ийн сүүдэрлэлтэд өртөж буй өвөлжөө байгаа эсэхийг тогтоох зорилгоор өвөлжөөнүүдийн байршлыг газрын зурагт тэмдэглэв.

¹⁹ ОУСК (2015) Салхин цахилгаан станцын Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зөвлөмж, хуудас 12

Зураг 4.1 Сайншанд салхин цахилгаан станцын сэнсний сүүдэрлэлтийн загвар



4.1.4 Сайншанд салхин цахилгаан станцын аюулгүйн бүс

Дуу чимээ, сэнснээс цас, мөс шидэгдэх, мөн доош унах эрсдэл зэрэгт дүн шинжилгээ хийсний дүнд Сайншанд салхин цахилгаан станцын хувьд хамгийн тохиромжтой аюулгүйн бүсийг 500 м байхаар тодорхойлов. Энэ нь Монгол улсын анхны салхин цахилгаан станц болох Салхитын салхин цахилгаан станцын аюулгүйн бүстэй (500 м) таарч байгаа юм. Дээр дурдсанчлан, сүүдэрлэлтийн нөлөөллийн бүсийг 30 цаг/жил байхаар тогтоож, зураг дээр арзгар шугамаар дүрслэн үзүүлсэн ба энэ нь аюулгүйн бүс болох 500 м-ийн зайтай тохирч байна.

500 метрийн аюулгүйн бүсийг СЦҮ тус бүрээс татаж тооцвол энэ нь нийт 912 га газрыг хамарч буй бөгөөд үүнийг Зураг 4.2-т шар өнгөөр тэмдэглэн харуулав. СЦҮ-ээс газрын гадаргад үзүүлэх нөлөө, мөн үүнтэй холбоотой аюулгүйн бүс нь Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын нутгийг хамарч байна. Эдгээр сумын хилийн заагийг Зураг 4.2-т ягаан өнгөөр тэмдэглэсэн ба нутгийн хойд хэсэгт Алтанширээ, баруун хэсэгт Сайншанд, зүүн хэсэгт Өргөн сум оршдог. Зургаас харагдаж байгаагчлан, төслийн газрын нөлөөлөлд Өргөн сум нэлээд их өртөж байна.

Зураг 4.2 Аюулгүйн бүс



Хүснэгт 4.1 Нөлөөлөлд өртсөн сумдад оногдох аюулгүйн бүсийн хэмжээг тооцов

Хүснэгт 4.1 Сайншанд салхин парк төсөл хэрэгжих талбайн хэмжээ, сумдаар

Сум	Төслийн талбайн хэмжээ (га)	Сумын газар нутгийн хэмжээ (га)	Сумын газар нутгаас төслийн талбайд орсон газрын хувь
Сайншанд сум	166.9	2,917,400	0.006%
Өргөн сум	674.5	870,000	0.08%
Алтанширээ сум	70.7	722,500	0.01%
НИЙТ	912.1	4,509,900	0.02%

4.1.5 Төслийн газрын шаардлага

Сайншанд салхин парк төслийн барилга угсралт болон үйл ажиллагааны үе шатаас хамааран төслийн газарт тавигдах хорио цээр өөр байна:

- Бүх нийтийн болон малын аюулгүй байдлыг хангах үүднээс төслийн барилгын угсралтын ажлын үеэр аюулгүйн бүсэд нэвтрэхийг хориглоно.

- Төслийн үйл ажилагааны үед малаа төслийн талбайд бэлчээрлүүлэхэд ямар нэг хориг байхгүй (25 ширхэг СЦҮ-ийн дэргэдээс бусад газар) хэдий ч малчид гэр сууцаа энэ бүс дотор барихыг хориглоно.

Зураг 4.3 Төслийн талбайн дүр зураг



1. СЦҮ-үүдийг суурилуулах тэгш өндөрлөгийн орой хэсэг

2. СЦҮ-үүдийг суурилуулах тэгш өндөрлөгийн ерөнхий дүр зураг

4.2 Төслийн нөлөөллийн тодорхойлолт

Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор нутгийн зарим малчин өрх ашиглаж буй бэлчээрээ түр болон бүр хугацаагаар чөлөөлөх шаардлагатай болсон. Малчдын өртөж буй нүүлгэн шилжүүлэлтийн төрөл болон нөхөн төлбөр авах эрхийн талаар Хүснэгт 4.2 тайлбарлав.

Хүснэгт 4.2 Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл

Нүүлгэн шилжүүлэлтийн ангилал	Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл/хохирлын нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр ба төрөл	Хууль ёсны эрх олгогдох нөхцөл
А	Бодит нүүлгэн шилжүүлэлт – өвөлжөөний газраа бүрмөсөн алдах	СЦҮ-ийн үйл ажиллагаа, СЦҮ тус бүрээс 500 метрийн зайд тогтоосон аюулгүйн бүс. Аюулгүйн бүсээс дотогш суурьшлын аливаа төрлийг хориглоно. Энэ нөхцөлд өвөлжөөг суурьшлын хэлбэр (орон байр) гэж үзнэ.	Өвөлжөөг тасалбар болгох өдрөөс (2016 оны 11 сарын 15) өмнө аюулгүйн бүсэд оршиж байсан өвөлжөө. Тухайн өвөлжөө албан ёсны зөвшөөрөлтэй, аль эсвэл зөвшөөрөлгүй байхаас үл хамаарна.
В	Бодит нүүлгэн шилжүүлэлт – хувийн өмчинд буй газар, эсвэл үл хөдлөх хөрөнгийг өөр газарт шилжүүлэх	СЦҮ-ийн үйл ажиллагаа, СЦҮ тус бүрээс 500 метрийн зайд тогтоосон аюулгүйн бүс. Энэ нөхцөлд өвөлжөөг суурьшлын хэлбэр (орон байр) гэж үзнэ.	Өвөлжөөг тасалбар болгох өдрөөс (2016 оны 11 сарын 15) өмнө аюулгүйн бүсэд оршиж байсан хувийн өмчийн газар, эсвэл үл хөдлөх хөрөнгө
С	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – зуслангийн бэлчээрийг түр хугацаагаар алдах	Иргэдийн болон мал сүргийн аюулгүй байдлыг хангах зорилгоор төслийн барилга угсралтын ажлын үеэр төсөл хэрэгжих талбай болон аюулгүйн бүсэд нэвтрэхийг хориглоно. Энэхүү нөлөөлөл нь	Төслийн талбайд зусдаг малчид (2016 онд хийсэн өрхийн судалгаанд бүртгэгдсэн). Малчид зуслангийн бэлчээрээ тухайн жилийн цаг агаар, бэлчээрийн гарцаас шалтгаалан өөр өөр газарт сонгодогтой холбогдуулан зуслангийн тасалбар болгох өдрийг

		барилга угсралтын ажил хийгдэхээр төлөвлөгдөж буй 2 зуны улиралд (2017 болон 2018) үргэлжилнэ. Энэ хугацаанд төслийн талбайг хамгаалалтын ажилтнууд хамгаалахаас гадна 500 метрийн зайд аюулгүйн бүсийн хил дээр анхааруулга тэмдгүүдийг байрлуулна. Хайс хашаа барихгүй. Төслийн талбайд нэвтрэхийг хориглосон талаар малчдад тайлбарлаж, тодорхой ойлголт өгнө.	2017 болон 2018 онуудад зун нэлээд эртнээс тогтоож, иргэдэд мэдэгдэнэ.
D	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – бэлчээрийн эвдрэл, доройтол	Төслийн талбай доторх болон төв замтай холбогдох авто замын ажил, дэд станцыг Сайншандын дэд станцтай холбох цахилгаан дамжуулах шугам барих гэх мэт бүтээн байгуулалтын ажил.	Төслийн бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил хараахан эхлээгүй байгаа тул одоогийн байдлаар бэлчээрийн эвдрэл явагдаагүй байна.
E	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – усны эх үүсвэр бүхий газарт нэвтрэх боломжгүй болох	Төслийн талбайд нэвтрэх хоригоос болж гар болон гүний худаг ашиглах боломжгүй болох магадлалтай.	Төслийн барилга угсралтын ажлын үеэр нэвтрэхийг хориглосон бүсэд байрлах усны эх үүсвэрийг ашиглах боломжгүй болсон тохиолдолд

Зураг 4.4-т төслийн талбайн ойр орших өвөлжөөний байршлыг дүрслэн харуулав. Эдгээр байршлыг хээрийн судалгаа, нөлөөлөлд өртсөн малчидтай хийсэн уулзалт ярилцлага, бүртгэлтэй малчид болон газар ашиглах зөвшөөрлийн талаарх багийн удирдлагуудаас авсан мэдээлэл болон бусад малчидтай хийсэн уулзалт ярилцлагын үр дүнд тогтоосон. Эндээс үзвэл, төслийн аюулгүйн бүс дотор хоёр өвөлжөө байрлаж байна. Энэ хоёр өвөлжөөний байршлыг төслийн аюулгүйн бүстэй харьцуулан Зураг 4.5-т илүү тодорхой харуулав²⁰.

²⁰ Өргөн сумд бүртгэлтэй хаваржааны байршил 4-р өрхийн өвөлжөө, зуслангийн байршилтай давхцаж байгааг энэ зураг дээрээс тодорхой харж болохоор байна. Энэ давхцалыг багийн удирдлага, албан тушаалтнууд харж, анхааралдаа авсан.

Зураг 4.4 Төслийн талбайн ойролцоох өвөлжөөний байршил



Зураг 4.5 Төслийн талбайн ойролцоох өвөлжөөний томруулсан зураг



Зураг 4.6-д төслийн талбайд ойр орших зуслангийн байршлыг дүрслэн харуулав. Эдгээр байршлыг 2016 оны зуслангийн байршил дээр үндэслэн тодорхойлсон бөгөөд тухайн жилийн бэлчээрийн гарцаас шалтгаалан эдгээр байршил өөрчлөгдөх боломжтой. 2016 оны байдлаар хоёр өрх төслийн аюулгүйн бүс дотор, хоёр өрх төслийн талбайгаас зайдуу (бог малын бэлчээрийн газар болох 5 км хүртэлх газарт) зусаж байв.

Зураг 4.6 Төслийн ойролцоох зуслангийн газрын байршил



Судалгаанд хамрагдсан долоон малчин өрхийн нөлөөлөлд өртөж буй байдлыг дараахь байдлаар тодорхойлж болохоор байна:

Хүснэгт 4.3 Судалгаанд хамрагдсан өрхүүдийн өвөлжөө ба зуслангийн байршил

Өрхийн дугаар	Өвөлжөөний байршил	Зуслангийн байршил
HH1	Аюулгүйн бүс дотор	Бэлчээрийн хязгаар дотор
HH2	Аюулгүйн бүсийн гадна	Бэлчээрийн хязгаарын гадна
HH3	Аюулгүйн бүсийн гадна	Бэлчээрийн хязгаар дотор
HH4	Аюулгүйн бүсийн гадна	Бэлчээрийн хязгаар дотор
HH5	Аюулгүйн бүсийн гадна	Бэлчээрийн хязгаар дотор
HH6	Аюулгүйн бүсийн гадна	Бэлчээрийн хязгаарын гадна
HH7	Аюулгүйн бүс дотор	Бэлчээрийн хязгаарын гадна

Эх үүсвэр: Тэкол ХХК, 2016

Малчдын өвөлжөө, зуслангийн байршилд хийсэн дүн шинжилгээн дээр үндэслэн нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийг урьдчилсан байдлаар Хүснэгт 4.4-т үзүүлэв. Дээр дурдсан таван төрлийн нүүлгэн шилжүүлэлтээс тус төслийн хүрээнд зөвхөн хоёр төрлийн (А ба С) нүүлгэн шилжүүлэлт хийгдэхээр байна.

Хүснэгт 4.4 Нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөллийн урьдчилсан тойм

Нүүлгэн шилжүүлэлтийн ангилал	Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл/хохирлын нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр ба төрөл	Нөлөөлөлд өртсөн өрхийн тоо
A	Бодит нүүлгэн шилжүүлэлт – өвөлжөөний газраа бүрмөсөн алдах	СЦҮ-ийн үйл ажиллагаа, СЦҮ тус бүрээс 500 метрийн зайд тогтоосон аюулгүйн бүс. Аюулгүйн бүсээс дотогш суурьшлын аливаа төрлийг хориглоно. Энэ нөхцөлд өвөлжөөг суурьшлын хэлбэр (орон байр) гэж үзнэ.	2 өрх
B	Бодит нүүлгэн шилжүүлэлт – хувийн өмчинд буй газар, эсвэл үл хөдлөх хөрөнгийг өөр газарт шилжүүлэх	СЦҮ-ийн үйл ажиллагаа, СЦҮ тус бүрээс 500 метрийн зайд тогтоосон аюулгүйн бүс. Аюулгүйн бүсээс дотогш суурьшлын аливаа төрлийг хориглоно. Энэ нөхцөлд өвөлжөөг суурьшлын хэлбэр (орон байр) гэж үзнэ.	Төслийн талбайд хувийн өмчийн газар байхгүй. Тиймээс энэ нөлөөлөлд өртсөн өрх байхгүй.
C	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – зуслангийн бэлчээрийг түр хугацаагаар алдах	Иргэдийн болон мал сүргийн аюулгүй байдлыг хангах зорилгоор төслийн барилга угсралтын ажлын үеэр төсөл хэрэгжих талбай болон аюулгүйн бүсэд нэвтрэхийг хориглоно. Энэхүү нөлөөлөл нь барилга угсралтын ажил хийгдэхээр төлөвлөгдөж буй 2 зуны улиралд (2017 болон 2018) үргэлжилнэ.	2016 оны судалгааны материал дээр үндэслэн, энэ нөлөөлөлд 3-4 өрх өртөх магадлалтай гэж дүгнэсэн. 2017 болон 2018 оны зун эрт дахин нягтлах шаардлагатай.
D	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – бэлчээрийн эвдрэл, доройтол	Төслийн талбай доторх болон төв замтай холбогдох авто замын ажил, дэд станцыг Сайншандын дэд станцтай холбох цахилгаан дамжуулах шугам барих гэх мэт бүтээн байгуулалтын ажил.	Наадмын морь барианы газар болон бусад үйл ажиллагааны (ж.нь, нарны эрчим хүчний үйлдвэр) улмаас төслийн талбай болон Сайншанд хотын хоорондох бэлчээр хэдийнээ эвдэрч доройтсон бөгөөд нүүлгэн шилжүүлэлтээр учрах нэмэлт нөлөөлөл байхгүй. Энэ хэсгийн бэлчээрийн чанар муудсанаас гадна зам, шугам сүлжээ гэх мэт дэд бүтцийн сүлжээ нэлээд их. Нэмж баригдах шугам сүлжээ бэлчээрийн одоогийн доройтлыг нэмэгдүүлэхгүй гэж үзэж байна.
E	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – усны эх үүсвэр бүхий газарт нэвтрэх боломжгүй болох	Төслийн талбайд нэвтрэх хоригоос болж гар болон гүний худаг ашиглах боломжгүй болох магадлалтай.	Усны эх үүсвэр бүхий газрууд төслийн нөлөөнд өртөөгүй тул үүнээс шалтгаалсан нүүлгэн шилжүүлэлт хийгдэхгүй.

5 НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 Гол зарчим

ССП төслийн нүүлгэн шилжүүлэлт, амьжиргааг нөхөн сэргээх үйл явцад дараах гол зарчмыг баримтлана:

- Газар эзэмших үйл явцад Монголын хууль тогтоомж болон олон улсын стандартыг мөрдөх;
- Нөхөн төлбөрт нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг бүрэн багтаах;
- Нөхөн төлбөрийг бодит хэлбэрээр олгохыг эрмэлзэх;
- Хээрийн судалгааны явцад олж авсан бодит мэдээлэл болон засаг захиргааны нэгж, бусад айл өрхөөс авсан мэдээлэлд үндэслэн төслийн нөлөөнд өртсөн айл өрхийг тодорхойлох;
- Зөвхөн тасалбар болгох өдрөөс өмнө бүртгэгдсэн айл өрхөд нөхөн төлбөр олгох;
- Барилга угсралтын болон үйл ажиллагааны үе шатад газрын хязгаарлалтыг байж болох хамгийн бага түвшинд байлгах;
- Санал, гомдлын механизмыг тасралтгүй явуулах;
- Төслийн нөлөөнд өртөх айл өрхөд мэдэгдэх, зөвдөлдөх;
- Эмзэг бүлгийн хүмүүсийг тодорхойлж, шаардлагатай үед туслалцаа үзүүлэх.

5.2 Газрын хязгаарлалтыг багасгах

ССП төсөл нь Сайншанд сумын хүн ам сийрэг тархсан газар хэрэгжих юм. Төслийн талбай, аюулгүйн бүсэд хувийн өмчийн газар байхгүй. Ард иргэдийн аюулгүй байдлыг хангахын тулд төслийн аюулгүйн бүсийг тодорхойлсон. Төсөлд өртөх газрын хэмжээ, мөн түүнтэй холбоотой газрын хязгаарлалтыг хамгийн бага байлгахын тулд дараах нөхцлийг хэрэгжүүлнэ:

- Барилга угсралтын ажлын үед зуны бэлчээрт тавигдах хязгаарлалтыг барилгын ажлын хуваарьтай уялдуулан аль болох багасгахыг хичээнэ. Аюулгүйн бүсийг хамгаалалтын ажилчид хянах ба барилга угсралтын болон үйл ажиллагааны үед газар ашиглалтыг хязгаарлах талаар тайлбарлаж, хил заагийг тогтооно.
- Үйл ажиллагааны үед ССП төслийн талбайд чөлөөтэй нэвтрэх боломжтой (СЦҮ-ийн эргэн тойрноос бусад газарт). Үйл ажиллагааны үед малчид төслийн талбайд малаа чөлөөтэй бэлчээлж болох ч төслийн аюулгүйн бүс дотор амьдарч болохгүй. Нийт ард иргэдийн аюулгүй байдлыг хангахын тулд төслийн аюулгүйн бүс дотор зусах, өвөлжихийн хориглоно.

5.3 Нөхөн төлбөр ба түүнийг олгох нөхцөл

ССП төслийн нөхөн төлбөр болон түүнийг олгох нөхцөлийг 5.1 хэсэгт дурдсан зарчимд үндэслэн боловсруулсан. Хоёр төрлийн нүүлгэн шилжүүлэлтэд (бодит нүүлгэн шилжүүлэлт – төрөл А, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – төрөл С) тохирсон нөхөн төлбөрийн нөхцөлийн талаар доор өгүүлэв.

5.3.1 Бодит нүүлгэн шилжүүлэлт (Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл А)

Ард иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс СЦҮ ба түүнд хамгийн ойр орших орон байрын хооронд аюулгүйн бүсийг тогтоосон. ССП төслийн хувьд аюулгүйн бүсийг 500 метрээр тогтоов (трубины сэнснээс цас, мөс шидэгдэх эрсдэл, сэнсний сүүдэрлэлт, дуу чимээний нөлөөллийг тооцоолсон). Тиймээс, ССП төслийн үйл ажиллагааны явцад СЦҮ-ээс 500 метрийн зай дотор орон байр барьж, амьдрахыг хориглоно.

Нүүдэлчин малчдын хувьд, өвөлжөөг суурьшлын хэлбэр буюу орон байр гэж үзнэ. Малчид өвөлжөөндөө жилийн 5 сар орчим хугацаанд нутаглаад, дараа жилийн өвөл мөн тийм хугацаагаар нутаглах гэх мэтээр давтагддаг. Одоогийн байдлаар малчид зөвхөн өвөлжөө/хаваржааны газраа хууль ёсоор эзэмших гэрчилгээ авах эрхзүйн орчин бүрдээд байна. Сайншанд, Өргөн сумын нутаг

дахь өвөлжөөнд тохиромжтой газрууд аль хэдийн “эзэнтэй” болсон учраас эдгээр сумдад өвөлжөөний газар маш бага үлдсэн.

ССП төслийн улмаас хоёр өвөлжөөг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай бөгөөд тэдгээрийн нэг нь зөвшөөрлийн гэрчилгээтэй. Энэ хоёр өвөлжөөнд ямар ч байгууламж, эд хогшил байхгүй. Нэг өвөлжөөнд малын бууц байх агаад энэ нь өвлийн хүйтэнд малыг дулаан байлгахад ач холбогдолтой.

Өвөлжөөнд буух хугацааг тасалбар болгох өдөр өнгөрсний дараа багийн засаг захиргааны төлөөллүүд нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдтэй нүүлгэн шилжүүлэлтийн талаар санал солилцож, зөвшилцөнө. Дараах элементүүд оролцсон нөхцөлд нөхөн төлбөр олгоно²¹:

- **Өвөлжөөг нүүлгэн шилжүүлэх** – бодит нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхүүдийн амьдралын түвшинг дээшлүүлэхийн тулд ССП төсөл нь малчин өрхүүд болон багийн засаг захиргаатай хамтран өвөлжөөг нүүлгэх газрыг тогтоож, шинэ өвөлжөөнд малын хашаа, саравч барьж өгнө. Харин нүүдэлчин малчдын уламжлалын дагуу, малчдын гэрийг нүүлгэхэд төслийн оролцоо шаардлагагүй. Нөлөөлөлд өртсөн хоёр өрхийн өвөлжөөнд ямар нэг байгууламж, эд хогшил байхгүй тул эдгээр өрхөд олгох нөхөн төлбөрийг тооцохдоо шинэ өвөлжөөнд малын хашаа, саравч барихад шаардлагатай зүйлсийг авч үзсэн. Амьжиргааны түвшин буурснаас болж малчин өрхүүдэд учрах санхүүгийн эрсдэлийг бууруулахын тулд нөхөн төлбөрийг бодит хэлбэрээр төлнө. Гэхдээ, хэрэв малчин өрх нөхөн төлбөрийг бэлэн мөнгөөр авах хүсэлтээ илэрхийлж, энэ нь тэдний амьдралын түвшинд муугаар нөлөөлөхгүй гэж үзсэн тохиолдолд дээрх байгууламжийг барихад шаардагдах зардалтай тэнцэх мөнгийг олгоно.
Нөлөөлөлд өртсөн малчид болон багийн засаг захиргааны төлөөллүүдийн оролцоотойгоор шинэ өвөлжөөний газрыг сонгоно. Энэ сонголтыг хийхдээ биологийн олон янз байдлын амьдрах орчин болсон газруудад нэмэлт нөлөө үзүүлэх, дарамт болохгүй байхад анхаарах нь зүйтэй.
- **Усны шинэ эх үүсвэрийг бий болгох** – малчдыг шинэ өвөлжөөнд нь усаар хангахын тулд өвөлжөө тус бүрт (эсвэл ойр орчимд) гар худаг гаргах боломжийг Төсөл эрж хайна. Гар худгийг 10-30 метрийн гүнээс гаргах боломжтой гэж үзэж буй бөгөөд худгийн ус хэт давсархаг биш гэдгийг тодорхойлохын тулд усны чанарыг шинжлүүлэх шаардлагатай.
- **Өвөлжөөний эд хогшлыг тээвэрлэх** – өвөлжөөн дээрх эд хогшлыг шинэ өвөлжөө рүү зөөж тээвэрлэх ажлыг Төсөл гүйцэтгэнэ. Энэ ажлын хүрээнд дээрх хоёр өвөлжөөний нэг дээр буй малын өтөг бууцыг шинэ өвөлжөө рүү зөөх ажил хийгдэнэ.
- **Эзэмшлийн аюулгүй байдал** – тухайн өвөлжөөг эзэмших эрхийг нь баталгаажуулж өгөхийн тулд газар эзэмших зөвшөөрлийн гэрчилгээ авахад нь малчин өрхөд тусална. Шинэ өвөлжөөний байршлаас шалтгаалан тухайн малчин өрх засаг захиргааны бүртгэлээ өөрчлөх шаардлага гарах магадлалтай. Өөрөөр хэлбэл, нэг сумаас нөгөө суманд шилжих. Засаг захиргааны харьяалал шилжихтэй холбоотой гарах зардлыг Төсөл хариуцна.
- **Амьжиргааг нөхөн сэргээх** – бодит нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн малчин өрхүүд нүүдэл суудлаас улбаатай эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд мөн өртөх боломжтой. Нөлөөлөлд өртсөн малчин өрхүүд нөхөн төлбөрөө мал, малын тэжээл гэх мэт бодит хэлбэрээр авах боломжтой.

²¹ Хэлэлцээр хийх үйл явцын турш нөхөн төлбөр олгох тогтолцоонд том өөрчлөлт гарвал НШТ-нд тухайн нөхөн олговрын зарчмын өөрчлөлтийг тусган шинэчилнэ.

5.3.2 Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт (Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл С)

Төслийн барилга угсралтын ажлын үед (2017 оны зуны эхэн – 2018 оны зуны эцэс) төслийн талбайн аюулгүйн бүсээс дотогш нэвтрэхийг хориглоно. Энэ хэсгийн нутгийг малчид зуны улиралд бэлчээрийн зориулалтаар ашигладаг учраас төслийн барилга угсралтын ажлын үеэр малчид энэхүү бэлчээрийг ашиглах боломжгүй болох юм. Түүнчлэн ССП төслийн үйл ажиллагааны туршид малчид аюулгүйн бүсийн дотор зусах боломжгүй болно.

Монгол улсын нөхцөлд, бэлчээр нь бүх нийтийн хэрэглээнд байдаг нөөц учраас үүнтэй холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь зөвхөн нөлөөлөлд өртсөн айл өрх төдийгүй нийт ард иргэд рүү чиглэгдэх ёстой. Тиймээс дараах арга хэмжээг санал болгож байна:

- **Гүний худаг гаргах** – Гүнийн худаг шинээр гаргаснаар зуслангийн бэлчээрийн талбай тэлэгдэнэ. Зуслангийн бэлчээрийн байршлыг тодорхойлоход уст цэгийн байршил чухал нөлөөтэй бөгөөд усны шинэ эх үүсвэрийг (төслийн талбайгаас зүүн урагш нэлээд магадлалтай) бий болгосноор зуслангийн бэлчээрийн сонголт нэмэгдэнэ. Гүнийн худгийн гүн ойролцоогоор 100 метр байдаг бөгөөд худгийн насос, насосыг ажиллуулах цахилгааны эх үүсвэрийг Төсөл хариуцан хангана.
- **Амьжиргааг нөхөн сэргээх** – Төслийн талбайн ойр орчимд зусдаг малчин өрхүүдийг эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн гэж үзэн, нөхөн төлбөрийг малын тэжээл хэлбэрээр олгоно. Энэ нөхөн төлбөр гурван өрхөд олгогдоно гэж үзэж буй боловч зуслангийн бэлчээрийн тасалбар болгох өдрөөр баталгаажна. Нөхөн төлбөр олгогдох өрхийг үнэн зөв тогтоох, тохиолдлын чанартай нүүдлээс үүдэлтэй эрсдэлийг бууруулахын тулд тасалбар болгох өдрийг оновчтой тогтоох шаардлагатай. Нөхөн төлбөр авах эрх бүхий малчин өрхүүдэд 2 жилийн хугацаанд (төслийн барилга угсралтын ажлын үеэр), гурван сарын туршид (зуны улирал) малын тэжээл олгоно. Нөлөөлөлд өртсөн малчин өрхтэй байгуулах гэрээнд малчин өрхүүд төслийн барилга угсралтын ажлын үеэр ямар ч шалтгаанаар төслийн талбайд буцаж ирэхгүй байх шаардлагыг тусгана.

Хүснэгт 5.1-т ССП төслийн нөхөн төлбөр олгогдох эрх бүхий хүмүүс болон нөхөн төлбөр олгох нөхцөлийг нэгтгэн харуулав. Тасалбар болгох өдрүүдийг тогтоосны дараа л энэ асуудлаар нөлөөлөлд өртсөн өрхүүдтэй ярилцаж зөвшилцөнө. Нөхөн төлбөр олгох нөхцөлийн талаар дэлгэрэнгүй тайлбарыг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5.1 Нөхөн төлбөр олгох нөхцөл, түүнийг авах эрх ба төлбөр

Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл	Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл/хохирлын нөлөөлөл	Хууль ёсны эрх олгогдох нөхцөл	Нөхөн төлбөр
А	Бодит нүүлгэн шилжүүлэлт – өвөлжөөний газраа бүрмөсөн алдах	Өвөлжөөг тасалбар болгох үед (2016 оны 11 сарын 15) аюулгүйн бүсэд байсан өвөлжөө. Бүртгэлтэй болон бүртгэлгүй өвөлжөө аль аль нь орно.	- Өвөлжөөн дэх мал сүргээс орж ирэх жилийн орлогын 75%, үүн дээр нэмээд: - o 15 ямаа (10 эм, 5 эр) - o 15 хонь (10 эм, 5 эр) - o нэг өвөл хэрэглэх малын тэжээл - Малчидтай хамтран шинэ өвөлжөөний газар олох - Шинэ өвөлжөөний газраа бүртгүүлэхэд нь туслах (шаардлагатай тохиолдолд засаг захиргааны бүртгэлийг өөрчлөхөд мөн тусална) - Өвөлжөөнд байсан эд хөрөнгийг бүгдийг нь нүүлгэн шилжүүлэх (бууц гэх мэт) - Малын шинэ саравч барьж өгөх

			- Шинэ өвөлжөөний газарт гар худаг шинээр гаргах
С	Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт – зуны бэлчээрийг түр хугацаагаар ашиглах боломжгүй болсон	Төслийн талбайд зуншдаг байсан малчид (2016 онд өрхүүдээс цуглуулсан судалгааны мэдээлэлд тэмдэглэгдсэн). Цаг агаарын нөхцөл, бэлчээрийн гарцаас шалтгаалж зуслангийн бэлчээрийн байршил янз бүр байдагтай холбоотойгоор зуслангийн бэлчээрийн тасалбар болгох өдрийг 2017 он болон 2018 оны зуны эхэн сарын эхээр тогтоож, иргэдэд зарлаж мэдэгдэнэ.	- Төслийн талбайгаас зүүн урд зүгт насос, цахилгааны эх үүсвэр гэх мэт шаардлагатай эд ангиар бүрэн тоноглогдсон гүний худгийг барих. Ингэснээр зуслангийн бэлчээрийн талбайг тэлэх боломжтой (байршлыг малчидтай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлно) - Зусланд бэлчээдэг малын тоогоор 2 жил дараалан, нэг жилд зуны 3 сарын турш малын тэжээлээр хангана. Малын тэжээл Х 3 сар Х 2 жил

5.4 Эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх туслалцаа

Эмзэг бүлгийн хүмүүс гэдэгт хүйс, яс угсаа, нас, бие-сэтгэхүйн бэрхшээл, санхүүгийн боломж, нийгмийн байдал зэргээсээ шалтгаалан газар ашиглалт, нүүлгэн шилжүүлэлтийн сөрөг нөлөөлөлд бусдаас илүүтэй өртөх магадлалтай хүмүүсийг оруулна.

Энэхүү төслийн хувьд, эмзэг бүлгийн хүмүүсийг тогтоохдоо Монголын засгийн газрын баримталдаг дараах шалгуурыг ашигласан:

- Өрх толгойлсон эрэгтэй
- Өрх толгойлсон эмэгтэй
- Гэр бүлийн гишүүн нь бүрэн асаргаанд байдаг өрх
- Олон хүүхэдтэй өрх
- Ажилгүй хүмүүс
- Бага орлоготой/ цөөн хэдэн хөрөнгөөс өөр зүйлгүй өрх зэрэг багтана.

Хүснэгт 5.2 Эмзэг бүлгийн өрхүүд

Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл	Өрх толгойлсон, эрэгтэй	Өрх толгойлсон эмэгтэй	Гэр бүлийн гишүүн нь бүрэн асаргаанд байдаг өрх	Олон хүүхэдтэй	Ажилгүй	Бага орлоготой /өмчид суурилсан	Нийт өрхийн тоо
А – Бодит нүүлгэн шилжүүлэлт	0	0	0	0	0	0	0
С – Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт	1	1	0	0	0	1	3

Дээрхи ангиллын давхцлыг тооцож үзвэл, эмзэг бүлэгт багтах дараах 2 өрх байна:

- ~ Нэг өрх нь цөөн малтай, өрх толгойлсон эмэгтэй
- ~ Өөр нэг өрх нь өрх толгойлсон, ганц бие эрэгтэй

Эмзэг бүлгийн хүмүүст нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн төлбөрийн талаар тайлбарлан таниулж, хамгийн бага эрсдэл бүхий сонголт хийхэд нь тусална.

Нийт хүн амтай харьцуулбал, эмзэг бүлгийн хүмүүст нүүлгэн шилжүүлэлт илүү хүнд тусах магадлалтай тул тэдэнд нэмэлт тусламж шаардлагатай байж болох юм. Иймээс дараах нэмэлт арга хэмжээг санал болгож байна:

- ССП төсөл нь зуны улирал эхлэхээс өмнө эмзэг бүлгийн өрхүүдтэй уулзаж, 2017/18 онд төслийн талбайд нэвтрэх хязгаарлалтын талаар мэдсэн эсэхийг тодруулах.
- Шаардлагатай тохиолдолд Төсөл эмзэг бүлгийн малчин өрхүүдийн өмч хөрөнгийг зуслангийн шинэ бэлчээр рүү нь тээвэрлэж туслах.

6 ОРОЛЦОО БА САНАЛ ГОМДЛЫН МЕХАНИЗМ

6.1 Сонирхогч тауудын оролцоог хангах үйл ажиллагаа

Сайншанд салхин парк төсөл нь сонирхогч талуудтай үр дүнтэй харилцах хөтөлбөрийг боловсруулсан. Энэ нь ССП-ын Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө (СТОХТ) юм. Төслийн барилга угсралтын болон үйл ажиллагааны үед энэхүү оролцоо үргэлжилсээр байх бөгөөд зөвхөн газар ашиглалт, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой оролцооны үйл ажиллагааг доор дурьдсан болно.

Газар ашиглалт болон нүүлгэн шилжүүлэлтэд чиглэгдсэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ССП нь өвөлжөөний тасалбар болгох (2016.11.15) өмнө Сайншанд сумын 3-р баг, Өргөн сумын Сумын булаг багын төлөөллүүдтэй уулзан, төслийн нөлөөлөлд өртсөн малчдыг баталгаажуулж, тасалбар болгох өдрийг хэрэгжүүлэх талаар ярилцах ба тасалбар болгох өдрийн дараа хийгдэх эд хогшлын тооллогод оролцохыг урина.
- Тасалбар болгох өдрийн талаарх мэдээллийг төслийн нөлөөлөлд өртсөн малчдад тасалбар болгох өдөр юмуу, эсвэл түүнээс өмнө ССП өөрөө хэлж танилцуулна. Багийн удирдлагууд малчидтай холбогддог сувгаараа дамжуулан сонирхож буй талуудад тасалбар болгох өдрийг мэдэгдэнэ. Төслийн нөлөөлөлд өртсөн, мөн төслийг сонирхож буй малчдад зориулсан мэдэгдлийг Монгол хэл дээр бэлтгэнэ.
- Өвөлжөөний тасалбар болгох өдрийн дараа, төслийн нөлөөлөлд өртсөн малчдын эд хогшлын бүртгэл явуулна.
- Өвөлжөөний тасалбар болгох өдөр өнгөрч, эд хогшлын бүртгэл дууссаны дараа, өвөлжөөг нь нүүлгэн шилжүүлэх шаардлагатай малчидтай нөхөн төлбөр болон нөхөн төлбөр олгох нөхцөлийн талаар тохиролцоно. Мөн ССП төслийн үед хэрэгжүүлэх нүүлгэн шилжүүлэлт, төслийн талбайд нэвтрэхийг хориглох дараагийн алхмын талаар малчдад товч мэдээлэл өгнө.
- Нөхөн төлбөр олгох нөхцөл болон зарчимтай холбоотой ярилцаж тохиролцсон талаарх мэдээллийг энэхүү НШТ-нд монгол, англи хэл дээр тусгаж, нөлөөлөлд өртсөн малчдад танилцуулахаас гадна онлайн хэлбэрээр байршуулна.
- Хоёр дахь тасалбар болгох өдөр нь зуслангийн бэлчээрийн хязгаарлалтад өртсөн малчдад хамаатай. Тасалбар болгох өдрөөс өмнө Сайншанд сумын 3-р баг, Өргөн сумын Сумын булаг багтай энэ өдрийг ярилцаж тогтоно. Багийн удирдлагууд нь малчидтай харилцдаг сувгаа ашиглан сонирхож буй талуудад тасалбар болгох өдрийг мэдэгдэнэ. Төслийн нөлөөлөлд өртсөн, мөн төслийг сонирхож буй малчдад зориулсан мэдэгдлийг Монгол хэл дээр бэлтгэнэ.

- Зуны бэлчээрийн тасалбар болгох өдрөөс өмнө (хараахан зарлаагүй байгаа) ССП төслийн ойролцоо зусдаг байсан малчидтай холбогдон, зуны бэлчээрийн нөхөн төлбөрийн талаар хэлэлцэнэ. Тасалбар болгох өдрөөс өмнө тухайн газар өөр айл нэмж буусан бол тэр талаар мөн ярилцана.
- Зуны бэлчээрийн тасалбар болгох өдрийн дараа, төслийн нөлөөлөлд өртсөн өрхүүдийн эд хогшлын бүртгэлийг хийнэ.
- Бодит болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт үргэлжлэн явагдах ба тэдний амьдралын түвшин (бодит нүүлгэн шилжүүлэлт) дээшилсэн эсэх, амьжиргаа дахин сэргэсэн эсэхийг тасралтгүй үнэлж дүгнэнэ.

2016 оны 5 сард явуулсан өрхийн судалгаанд өрхүүд ССП төслийн талаар ямар сэтгэгдэлтэй байгаа талаар асууж лавласан. Судалгаанд оролцогчдын ихэнх нь Төслийн ажилтан, судалгааны багаас төслийн талаар мэдээлэл авсан байсан. Мөн зарим нь Төслийн талаар хөрш зэргэлдээх айлуудаасаа сонссон байв. Харин нэг өрх Төслийн тухай огт дуулаагүй хэмээж байлаа.

Судалгаанд оролцсон өрхүүдийн нэгээс бусад нь тэдэнд төслөөс ирэх ямар нэг үр өгөөж байхгүй гэж бодож буйгаа илэрхийлсэн. Мөн судалгаанд оролцсон зарим өрх төсөл хэргэжсэнээр ажлын байр бий болно гэж найдаж байгаагаа хэлж байв. Томоохон хөрөнгө оруулалттай төсөлтэй ойр амьдарч буй хүмүүсийн хувьд ажлын байр бий болох байх гэсэн хүлээлт үүсдэг байна.

Төслийн сөрөг үр дагаврын талаарх тэдний сэтгэгдлийг асуухад, бэлчээрийн доройтол, байгаль орчинд учруулах хор хөнөөл, хөл хөдөлгөөн ихэсч тайван байдал алдагдах зэрэг асуудлыг түлхүү дурдаж байв. Түүнчлэн судалгаанд хамрагдсан өрхүүд төслөөс шалтгаалж дуу чимээ, тоос шороо, газар сүйдэх гэх мэт асуудал үүснэ гэж үзэж байгаагаа илэрхийлж байв.

6.2 Санал, гомдлын механизм

6.2.1 Оршил

Төслийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үгээ хэлж, асуудлаа шийдвэрлүүлэх найдвартай арга зам орон нутгийн иргэдэд зайлшгүй байх шаардлагатай. Санал, гомдол барагдуулах механизмыг тухайн орон нутагт үндэслэн боловсруулснаар нутгийн иргэд болон компани харилцан уялдаатайгаар асуудлыг хамтран шийдвэрлэх боломжийг бүрдүүлж өгдөг. ССП компанийн боловсруулан хэрэгжүүлэх санал, гомдол барагдуулах механизм нь дараах зорилгыг агуулна:

- Аливаа жижиг санал зөрөлдөөн, маргааныг газар авахуулалгүй, түргэн шуурхай шийдвэрлэх
- Маргааныг орон нутгийн хил хязгаараас давуулахгүй байх
- Санал, гомдлыг цаг алдалгүй, бага зардлаар үр ашигтай шийдвэрлэх
- Эрсдэлийг бууруулж, орон нутгийн иргэдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа өндөржүүлэхэд тустай бизнесийн тогтвортой уур амьсгалыг дэмжин төлөвшүүлэх

Сайтар боловсруулсан гомдол, санал барагдуулах механизм нь дараах ач холбогдолтой:

- Харилцааг үр дүнтэй байлгах суваг болж өгдөг
- Тухайн компани олон нийт болон тэдний сайн сайхны төлөө санаа тавьдаг гэдгийг харуулдаг
- Компанийн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулдаг, мөн түүнээс урьдчилан сэргийлдэг
- Харилцан хүндлэл, итгэлцлийг дээшлүүлдэг
- Компанийн засаглалд тогтворгүй байдал үүсгэж буй асуудлыг тодорхойлон шийдвэрлэхүйц

зөв бүтцийг бий болгодог

- Үр өгөөжтэй харилцааг дэмждэг
- Компанийн үйл ажиллагааг олон нийтэд хүлээн зөвшөөрүүлдэг

ССП хэзээд төсөлтэй холбоотой үгэн болон бичгэн бүх санал, гомдлыг хүлээн авах болно. Санал гомдлын жишээ хуудсыг Хавсралт Б-д хавсаргав.

Төслийн санал, гомдлын механизмыг төслийн нөлөөлөлд өртсөн өрхийн нөхцөл байдал, хэрэгцээг анхаарахын тулд, мөн бүх гомдлууд ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт, Санал гомдлын механизмын дагуу оновчтой замаар шийдвэрлэгдэн, засах арга хэмжээнүүд авахын тулд загварчилсан. Үүнд:


- Гомдлыг хүлээж авах, тэмдэглэх, баримтжуулах, тодорхойлох хялбар, соёлд нь нийцсэн, нутгийн иргэд ойлгож чадах процедурыг байгуулах.
- Иргэд/компанийн оролцооны үед төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүст механизмын талаар танилцуулах.
- Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг оролцуулан санал гомдлыг хамтарч ажиллах замаар ямар шийдлээр, хэзээ шийдвэрлэж байх талаар эргэцүүлэх.
- Төслийн нөлөөлөлд өртсөн иргэд бүгд шууд хүлээн авахуйц ойлгомжтой, илэн далангүй байдлаар асуудлуудыг зориудаар анхаарлаа хандуулах.
- Бүх эрэгтэй эмэгтэй хүмүүсийг мөн эмзэг бүлгийнхнийг заавал оролцуулах.
- Тогтолцоог боловсруулж байх явцдаа маргааныг шийдвэрлэх энгийн болон уламжлалт аргыг аль алийг бодолцож үзэх.
- Санал, гомдлыг хүлээн авах хариуцлагыг үйлчлүүлэгчтэй харилцах байгууллагын туршлагатай, мэргэшсэн, тасралтгүй ажиллах албан тушаалтанд даалгах.
- Санал гомдол нь оновчтойгоор шийдвэрлэгдээгүй хүмүүс асуудлаа гадны байгууллагаар шийдвэрлүүлэх нөөцтэй байхад зориулсан засварлах механизм байгуулах.
- Ирсэн санал гомдол болон хариу арга хэмжээнүүдийг баримтжуулан тогтмол хугацааны үечлэлтэйгээр нийтэд эргүүлэн тайлагнах.
- Иргэдийн санааг зовоож буй асуудлуудын талаар тогтмол хугацааны зайтай мэдээллээр хангах.

Гүйцэтгэлийн стандарт болон Зааварчилгааны тэмдэглэлд цохон тэмдэглэснээр: ССП төслийн эрсдэл болон нөлөөний талаарх нутгийн иргэдийн бодлын ойлгон таарсан хэмжилт, үйлдлүүдийг авахад санал гомдлын механизм туслах ёстой гэсэн байна.

6.2.2 ССП-ын санал, гомдлын процесс

ССП компанийн хэрэгжүүлж буй төслөөс олон нийтийн санал, гомдлыг барагдуулах механизм буюу үйл ажиллагаа нь орон нутгийн иргэд, малчин өрх, төмөр замын ажилчид гэх мэт төслийн шууд нөлөөнд өртсөн хүмүүсийн гомдол, санал сэтгэгдлийг сонсож, зохих журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Түүнчлэн олон нийтээс хүлээн авсан гомдлын дагуу ямар арга хэмжээ авсан, хэрхэн засаж залруулсныг тогтоож, гарсан үр дүнг мэдээлэх үйл явцыг энэхүү механизмд (Хавсралт Б) тусгах учиртай. Сонирхогч талууд нь өөрсдийн санал, гомдлыг улс үндэстнийхээ соёл заншилд харш бус арга хэрэгслээр илэрхийлэх ёстой. Дараах диаграмд санал, гомдол барагдуулах ерөнхий механизмыг харуулав.

Зураг 6.1 Санал, гомдлын механизмын үе шатууд



6.2.3 Санал гомдлыг хүлээж авах

Ирсэн санал гомдол, сэтгэгдлийг Санал гомдлын дэвтэрт нэгтгэн бүртгэх ба бүртгэлийг хийхдээ гомдол, санал гаргагчийн овог, нэр/ бүлгийн нэр, хүлээн авсан огноо, асуудлын товч тайлбар, засаж залруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл (хэрэв шаардлагатай бол), гомдол, саналд хариу өгсөн огноог тэмдэглэнэ. Санал, гомдлыг хүлээн авсан тухайгаа 5 өдрийн дотор мэдэгдэж, ажлын 30 өдөрт багтаан хариу өгнө. Хэрэв асуудлыг нягтлан судлахад

нэмэлт хугацаа шаардагдахаар байвал энэ тухай гомдол гаргагчид мэдэгдэнэ. Санал гомдолтой танилцана гэдэг нь тухайн санал, гомдлыг хүлээн авах эсэх, хэрэв хүлээн бол шийдвэрлэх ямар алхам хийхээ тоймлохыг хэлнэ. Энэ нь санал гомдлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ гэсэн үг биш юм. Санал нь гомдолд тооцогдохгүй бөгөөд санал гаргагч хариу хүсээгүй л бол саналд хариу илгээхгүй.

Оролцогч гомдол гаргасан үед тэд дараахаас нэг ба түүнээс дээшийг хүлээн авна гэж найдаж байдаг:

- Тэдний асуудлыг судлан танилцах
- Компанийн үйл ажиллагааны талаарх асуултуудад үнэнээр хариулах
- Уучлалт гуйх
- Нөхөн олговор
- Гомдлын эх үүсвэрийг өөрчлөх үйл ажиллагааг явуулах
- Бусад засах шударга арга хэмжээг авах

Иргэд өөрсдийн асуудлаа илэрхийлэх үед тэднийг сайн сонсож, чухалчлан авч үзнэ хэмээн тэд найддаг. Эдгээд зарчмыг ССП компанийн гомдолд хариу илгээх зарчимд хэрэгжүүлнэ.

6.2.4 Санал, гомдлыг үнэлэх

Гомдол, саналд дүн шинжилгээ хийх явцад нөхцөл байдал, гол асуудлын талаар мэдээлэл цуглуулж, түүнийг хэрхэн шийдвэрлэж болох арга замыг тодорхойлно. ССП нь:

- Энэхүү үнэлгээг хариуцан хийх албан тушаалтныг тогтооно. Энэ ажлыг ихэнхдээ санал, гомдлыг барагдуулах ажлыг хариуцсан зохицуулагч гүйцэтгэдэг. Түүнчлэн энэхүү үүргийг үнэлгээний ажилтан юмуу хэлтэст (бүтээгдэхүүн, хангамж, байгаль орчин, нийгмийн харилцаа, ба хүний нөөц) даалгах тохиолдол байдаг.
- Гарсан санал, гомдлын үнэн мөн чанарыг газар дээрээс нь олж харуулахаар компанийг нэг ажилтныг сонгож, шууд тухайн нөхцөл байдал руу илгээнэ.
- Оролцогч талууд, гол асуудал, үзэл баримтлал, санал бодлыг тодруулна:
 - Оролцогч талуудыг тодруулах;
 - Санал гомдолд тусгагдсан гол асуудлыг тодруулах;
 - Компани доторхи болон бусад сонирхогч талуудын үзэл бодлыг цуглуулах;
 - Талуудын төсөөлж байсан анхдагч хувилбаруудыг тодорхойлж, асуудлыг шийдвэрлэх өөр арга замуудыг судлах;
- Санал, гомдлыг ноцтой байдлаар нь (их ноцтой, дунд зэрэг, бага) зэрэглэн ангилна. Хэр зэрэг ноцтой вэ гэдгийг тогтоохдоо компанид болон нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийг харгалзан үзнэ.

Нотолгоотой, хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүсийн сайн сайхан, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, аль эсвэл олон нийтийг хамарсан асуудлыг зайлшгүй авч хэлэлцэх ёстой. Түүнчлэн тухайн санал, гомдол хэр зэрэг ноцтой байна вэ гэдгээс шалтгаалан компанийн ямар албан тушаалтан түүнд хариу өгөх нь тодорхойлогдоно.

- “Судал, шийд, зарлан мэдэгд” гэсэн зөвхөн нэг талыг баримталсан бодлогын оронд гомдол, санал гаргагчийг өөрийг нь энэхүү үнэлгээ судалгааны үйл явцад оролцуулж, улмаар асуудлыг шийдвэрлэх хувилбаруудаас сонголт хийх боломжийг олгох нь зүйтэй.

6.2.5 Хариу арга хэмжээг тодорхойлох

Гомдол, санал гаргагчдад хариу өгөх тогтолцоог бүрдүүлэхдээ хэнтэй, хэрхэн харилцах вэ гэдгийг тодорхой зааж өгөх шаардлагатай.

Зарим тохиолдолд, гомдол, санал гаргагчтай харилцах, эргэх холбоо тогтоох ажлыг үнэлгээний ажилтан санал, гомдол барагдуулах ажлыг хариуцсан ажилтантай хамтран хариуцах нь зүйтэй байж болох юм.

Гомдол, санал хэр зэрэг ноцтой байна вэ гэдгээс шалтгаалан төслийн талбайд ажиллаж буй менежер энэхүү эргэх холбоог зохицуулах боломжтой.

Гомдол, саналд хариу өгөх арга замыг тодорхойлохдоо ССП компани дараах зүйлсийг баталгаажуулж өгнө:

- Санал, гомдол хариуцсан ажилтан, эсвэл хэлтэс тасаг тухайн санал, гомдолд хариу өгнө. Уг хариунд тухайн асуудлыг шийдэх үйл ажиллагааны талаарх гомдол, санал гаргагчийн үзэл бодлыг авч үзсэн байхаас гадна түүнийг засаж залруулах тодорхой арга замыг тусгасан байна. Түүнчлэн тухайн асуудлыг шийдэх арга замыг санал болгох, аль эсвэл урьдчилсан байдлаар зохицуулах хувилбарыг санал болгох боломжтой.
- Санал, гомдол гаргагчид хариу өгөх, энэ талаар дүгнэн ярилцахдаа гомдол, санал хариуцсан ажилтан, компанийн менежер болон санал, гомдол гаргагч нар хамтдаа уулзана. Хэрэв ийнхүү хамт уулзах боломжгүй бол хөндлөнгийн гуравдагч этгээдийг байлцуулна. Энэхүү уулзалт ярилцлагын үеэр дараагийн шатанд ямар алхмыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар мөн ярилцаж, санал бодлоо солилцоно. Хэрэв тухайн хариулт асуудлыг шийдвэрлэхэд хангалттай хэмээн хүлээн зөвшөөрөгдвөл тухайн гомдол, санал амжилттай шийдэгдэж, улмаар дараагийн алхам хийх шаардлагагүй болно. Харин, хэрэв гомдол, санал гаргагч тухайн хариултад сэтгэл хангалуун бус байвал уулзалтад оролцогсод харилцан хүлээн зөвшөөрөхүйц зөвшилцөлд хүрэхийг хичээх ёстой.
- Хэрэв нөхцөл байдал илүү төвөгтэй, асуудлыг тогтсон хугацаанд шийдвэрлэх боломжгүй нөхцөл үүсвэл гомдол, санал гаргагчид энэ талаар амаар юмуу бичгээр мэдэгдэж, учир шалтгааныг тайлбарлан, дараагийн алхмыг хийх хугацааг санал болгоно.

Газар ашиглах мөн нөхөн олговортой холбоотой гомдлуудыг ССП төслийн баг тодорхойлох нь зүйтэй. Гэвч зарим тохиолдолд тухайн гомдлын утга учраас шалтгаалан гомдлыг шийдвэрлэх үйл явцыг багийн удирдлагад танилцуулах нь зохистой. Монгол улсын хуульд хувийн секторууд өмчийг хураах талаар заалт байхгүй.

Газар ашиглалт болон нөхөн олговортой холбоотой гомдлуудыг шаардлагатай тохиолдолд ССП компанид өргөн барих болно. Нөхөн төлбөр олголттой холбоотой бүх гомдлуудыг автоматаар ахлах менежерт хүргэнэ.

6.2.6 Санал гомдлыг тэмдэглэн, хянах

Гарсан бүх санал, гомдлыг нэг бүрчлэн нягталж, хянаж байх шаардлагатай. Тэдгээрийг үр дүнтэй нягтлан шалгаж, баримтжуулснаар дараах хэд хэдэн зорилгыг гүйцэлдүүлнэ:

- Тухайн санал, гомдол хэр зэрэг ноцтой (их, дунд, бага) болохыг тодорхой шалгуурын дагуу ангилж бүртгэнэ. Ноцтой байдлын түвшин нь удирдах албан тушаалтанд тавигдах шаардлага, ажлын туршлагыг тодорхойлно.
- Гарч буй санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр бүртгэх хүртэл бүх процессыг ажиглах үүргийг тодорхой нэг хүнд хариуцуулна.
- Санал, гомдлыг тогтсон хугацаанд багтаан шийдвэрлэнэ.
- Тухайн нөхцөл байдал болон асуудлыг шийдэх явцад гарсан ахиц дэвшлийг холбогдох бүх хүнд (санал, гомдол гаргагч болон компанийн зохих ажилтан) мэдээллэнэ.
- Шударга ёс, тогтвортой байдлыг хөхиүлэн дэмжихийн тулд компанийн өгсөн хариулт

болон үр дүнг баримтжуулан тэмдэглэнэ.

- Сонирхогч талуудын хариу хандлагыг тэмдэглэж, нэмэлт судалгаа, эсвэл зөвшилцөл шаардлагатай эсэхийг тодруулна.
- Асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тэмдэглэл хийх ба энэ нь цаашид адил төстэй асуудлыг шийдэх стандарт ба шалгуурыг боловсруулахад тус болно.
- Тухайн асуудлыг цаг хугацаанд нь бүх талаар шийдсэн гэдгийг батлахын тулд хэрэгжилтэд хяналт хийнэ.
- Санал, гомдлыг барагдуулах явц, үйл ажиллагаа хэр үр нөлөөтэй байсныг үнэлэхийн тулд чанарыг хянан шалгахад шаардлагатай баримт мэдээгээр хангана.
- Тухайн механизм хэр үр нөлөөтэй болохыг үнэлэх, эсвэл компанийн бодлого юмуу гүйцэтгэлд өөрчлөлт хийхээс өөр аргагүй байдалд хүргэж буй асуудлыг шийдвэрлэхэд хожим хэрэг болохуйц онцгой нөхцөл байдлаас чухам юуг сургамж болгохоор байгааг тодорхойлно.

Гарсан санал, гомдлын мөрөөр эргэн судалж, баримтжуулдаг байхын тулд ССП компани нь дараах зүйлсээр хангана:

- Компанийн ажилтан болон санал, гомдол гаргагчаас мэдээлэл цуглуулах зорилготой *эргэн нягтлах маягт болон үйл явц*
- Санал, гомдлын мэдээллийн санг тогтмол шинэчлэх үүрэг бүхий *ажилтан*.
- Санал, гомдлын ерөнхий чиг хандлага ямар байгааг болон тогтолцооны түвшний учир шалтгаан бий эсэхийг тодорхойлох, ил тод байдлыг хөхиүлэн дэмжих, компани санал, гомдлыг хэрхэн барагдуулдаг болохыг олон нийтэд таниулах, тухайн механизмын үйл ажиллагааг бүхэлд нь тогтмол үнэлэхийн тулд *мэдээллийг тодорхой хугацаанд хянах*.
- Үүссэн нөхцөл байдлын талаар *сонирхогч талуудад мэдээлэх үйл явц* (бичмэл тайлан гэх мэт).
- Санал, гомдол болон тэдгээрийг хэрхэн барагдуулсан талаар тогтмол тайлагнах *үйл явц*.

6.2.7 Үүрэг хариуцлага

Санал, гомдлоо илэрхийлэхийг хүссэн хувь хүн, байгааллагын алин боловч дараах хаягаар хандах боломжтой:

Хүснэгт 6.1 Холбоо барих хаяг

Ferrostaal Industrial Projects GmbH Федерика Пелзер Төслийн ахлах менежер Ferrostaal Industrial Projects GmbH Email: Federica.Pelzer@ferrostaal.com Утас: +49 (0)201 818 1637 Гар утас: +49 (0)171 5666882	Сайншанд салхин парк Д.Нандинбаяр Менежер Сайншанд салхин парк ХХК DHL барилга, 9 давхар Улаанбаатар хот Монгол улс Имэйл: nandinbayar@euro-khan.com Утас: +976-99990416
---	---

Дээрх хаягаас гадна төслийн талбай руу нэвтрэх хаалган дээр орон нутгийн иргэдийн гомдол саналыг хүлээн авах хайрцаг байрлуулна.

7 МОНИТОРИНГ БА ҮНЭЛГЭЭ

Мониторинг болон үнэлгээ нь гурван элментээс бүрдэнэ:

- ССП компанийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан багийн явуулах дотоод мониторинг;
- Нүүлгэн шилжүүлэх, амьжиргааг нөхөн сэргээх талбарт мэргэшсэн зөвлөхөөр хийлгэх үр дүнгийн үнэлгээ;
- НШТ-ний хэрэгжилтийн аудит.

Хүн ам, өрх мөн/эсвэл хувь хүмүүст нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа нь урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүйг баттай болгохын тулд үр дүнтэй мониторинг ба үнэлгээ маш чухал юм.

Энэхүү бүлэгт гадаад болон дотоод мониторингийн аргазүй, индикатор, мониторинг болон үнэлгээний үйл явцыг хариуцах баг, тайлагнах давтамж, гадаад болон дотоод мониторингийн агуулга мөн гадаад мониторингээс ирсэн эргэх холбоог төсөл хэрэгжүүлэх процесст тусгах тухай тайлбарлана.

7.1 Мониторинг

НШТ-ний хүрээнд хийгдэх үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүн, зорилго, зорилтыг үнэлж дүгнэхийн тулд дээрх шалгууруудыг тогтоосон. Гүйцэтгэлийн мониторинг/хяналт үнэлгээний таван төрлийн шалгуурын эхний гурав нь орц, гарц болон үйл явцын шалгуур юм. НШТ хэр өгөөжтэй, үр дүнтэй байгаад хяналт тавьж үнэлэхэд энэ гурван шалгуурыг ашиглах ба энэ нь дунд хугацааны үнэлгээ байдаг. Сүүлийн хоёр шалгуур буюу үр дүн ба нөлөөллийн шалгуурыг голчлон урт хугацааны үр дүнд хяналт үнэлгээ хийхэд ашиглана.

- *Орцын шалгуур* гэдэгт НШТ-г хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд ашиглагдсан хүний болон санхүүгийн нөөцийг ойлгоно;
- *Гарцын шалгуурт* орцыг ашиглан явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэж буй үйлчилгээ багтана. Тухайлбал, газар ашиглалтын талаарх мэдээллийн сан, үл хөдлөх хөрөнгөө алдсаны төлөө олгох нөхөн төлбөр зэрэг нь НШТ дэх гарцын шалгуур болно;
- *Үйл явцын шалгуур* нь НШТ хэрэгжихийн өмнө болон хэрэгжсэний дараа үл хөдлөх хөрөнгийн тоо чанарт гарсан өөрчлөлт, мөн үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ, хүртээмжид гарсан өөрчлөлтийг илтгэн харуулна. Тухайлбал, гомдол, санал барагдуулах механизм боловсруулах, олон нийттэй харилцах, мэдээлэл түгээх сувгийг тодорхойлох гэх мэт үйл явц үүнд багтана;
- *Үр дүнгийн шалгуур* гэдэгт бодит болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтээс үүдсэн хохирлыг барагдуулах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, мөн нөлөөлөлд өртсөн өрхүүд болон нийт ард иргэдийн төсөлд хандах хандлагад гарсан өөрчлөлт багтана. Тухайлбал, мал аж ахуйн үйлдвэрлэл, ашиг орлогыг сэргээх, нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа гэх мэт;
- *Нөлөөллийн шалгуур* нь иргэдийн хандлага, зан байдал, амьдралын түвшин болон нөхцөлд дунд болон урт хугацааны туршид ямар өөрчлөлт гарч буйг тодорхойлно. Нөлөөллийн шалгуур нь НШТ-нд тусгагдсан амьжиргааг нөхөн сэргээх үйл ажиллагаанууд нь нөлөөлөлд өртсөн өрхүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг дээшлүүлэхэд хэр өгөөжтэй, үр дүнтэй байгааг үнэлэхэд чиглэгдэнэ.

7.1.1 Дотоод мониторинг

Орц, гарцын мониторинг нь ССП компанийн захирлын удирдлага дор хийгдэх дотоод мониторинг байна. ССП компанийн нийгмийн асуудал хариуцсан/олон нийттэй харилцах мэргэжилтэн энэ үйл явцыг хариуцах ба шаардлагатай тохиолдолд компаниас томилсон шинжээчийн туслалцааг авна.

Мониторингийг үр дүнтэй гүйцэтгэхийн тулд дараах арга хэрэгслээр мэдээлэл цуглуулах нь зүйтэй:

- Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн гэх мэтийг багтаасан албан ёсны баримт бичгүүд болон тайлангууд;
- Нүүлгэн шилжүүлэлтийн явцад цулуулсан тоо баримт;
- Холбогдох шинжээчдийн хээрийн ажиглалт, судалгааны ажлын тайлангууд;
- Гомдол, санал, хүсэлтийн бүртгэл, мэдээ;
- Ганцаарчилсан уулзалтуудын тэмдэглэл;
- Хээрийн судалгааны үе;

Төслийн мониторингийг барилга угсралтын ажилтай зэрэг эхэлж, гадаад мониторингтой зэрэг дуусгана. Дотоод мониторинг нь дараах зүйлсэд гол анхаарлаа хандуулна:

- Газар ашиглалттай холбоотой үйл явц; малын бэлчээр нь төслийн нөлөөнд өртсөн малчид бүгдээрээ НШТ-д тусгагдсан эрхийнхээ дагуу нөхөн төлбөр авсан эсэх;
- Гомдол, санал, хүсэлт барагдуулах механизм нь хүн бүрт хүртээмжтэй, ил тод байгаа эсэх;
- Орон нутгийн иргэд, засаг захиргааны ажилтнуудтай байнгын харилцаатай байх замаар нийгмийн болон техникийн асуудлыг шийдвэрлэх, учирсан асуудлыг ССП компанийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын баг зохих ёсоор шийдэж байгаа эсэх;

Сонирхогч талуудтай байнгыг харилцаа тогтоож, баримт нотолгоог системтэйгээр бүрдүүлснээр эдгээр үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх боломжтой.

Fehler! Verweisquelle konnte nicht gefunden werden.-т ССП төслийн нүүлгэн шилжүүлэлтийн үйл явцад хийх дотоод мониторингийг тоймлон харуулав.

Хүснэгт 7.1 Дотоод мониторингийн бүтэц

Мониторинг хийх хэсэг	Шалгуур ба хэмжүүр	Мониторингийн давтамж	Үргэлжлэх хугацаа	Хариуцах эзэн
НШТ-ний хэрэгжилт	- Нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдтэй нөхөн төлбөрийн асуудлаар харилцан зөвшилцөх үйл явцад гарч буй ахиц - Малчдад нөхөн төлбөр төлсөн байдал (орлуулах эсвэл бэлэн мөнгө) - Уг төлөвлөгөөнд дурдсанчлан мал худалдаж авч өгсөн эсэх - Уг төлөвлөгөөнд дурдсанчлан малын тэжээл авч өгсөн эсэх - Шинэ өвөлжөөний газарт гар худаг гаргах ажлын явц - Эмзэг бүлгийн хүмүүсийг дэмжсэн байдал - Өвөлжөөний шинэ газрыг сонгож тогтоосон, бүртгүүлсэн байдал	Сар бүр	2016 оны 11 сараас 2018 оны эцэс хүртэл	ССП компанийн Байгаль орчин/нийгмийн баг
Санал, гомдол, хүсэлт	- Нүүлгэн шилжүүлэлт, газар ашиглалтад тавьсан хориг болон нөхөн төлбөртэй холбоотой гарсан санал, гомдол, хүсэлтийн тоо - Гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэхэд зарцуулсан хугацаа	Сар бүр	2016 оны 11 сараас 2018 оны эцэс хүртэл	ССП компанийн Байгаль орчин/нийгмийн баг
Иргэдийн сэтгэл ханамж	- Төслийн газар ашиглалтын үйл явцад хандаж буй нөлөөлөлд өртсөн өрхүүдийн хандлага – ярилцлагын үед олж авсан мэдээлэл ба ажиглагдсан зүйл. - Өрхийн амьжиргаа, орлогыг нөхөн сэргээх үйл ажиллагаанд хандаж буй нөлөөлөлд өртсөн өрхүүдийн хандлага - ярилцлагын үед олж авсан мэдээлэл ба ажиглагдсан зүйл. - Олон нийтийн хэлэлцүүлэгт хандаж буй сонирхогч талуудын хандлага - ярилцлагын үед олж авсан мэдээлэл ба ажиглагдсан зүйл.	Тасралтгүй	Газар ашиглах эрх авахаас эхлээд амьжиргааг дээшлүүлэх төлөвлөгөө хэрэгжиж дуусах хүртэл	Төслийн талбай дээрх ССП компанийн төлөөлөл, Байгаль орчин/нийгмийн баг Амьжиргааг нөхөн сэргээх асуудлаар туршлагатай зөвлөх

7.1.2 Үр дүнгийн үнэлгээ

Үр дүнгийн үнэлгээний гол зорилго нь нүүлгэн шилжүүлэлтийн улмаас нөлөөлөлд өртсөн өрхөд учирсан сөрөг нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хэр үр өгөөжтэй байгааг тодорхойлоход оршино.

Гадаад мониторингийг газар ашиглалт, амьжиргааг нөхөн сэргээх ажлын туршлагатай зөвлөгчөөр хийлгэх нь илүү үр дүнтэй байдаг. Төслийн нийгмийн нөлөөлөлд мониторинг хийхийн тулд ССП төслийн дотоод мониторингийн тайланг хоёрдогч мэдээлэл болгон ашиглахаас гадна мониторинг хийж буй шинжээчийн газар дээр хийсэн ажиглалт, нөлөөлөлд өртсөн хүмүүстэй хийсэн ярилцлага нь анхдагч мэдээлэл болно. Үр дүнгийн үнэлгээ нь ерөнхийдөө шууд бус шалгуурууд дээр түшиглэдэг. Хүмүүс өөрсдийн орлого, амьжиргаа, хоол тэжээлийн хангамж, зарлага гэх мэт үйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөс татгалзах, эсвэл иймэрхүү төрлийн мэдээлэл өгөх боломжгүй үед шууд бус шалгуур ашиглах нь тустай байдаг.

Үр дүнгийн үнэлгээг жилд хоёр удаа хийж байхаар төлөвлөсөн. Гэхдээ нөлөөлөлд өртсөн цөөн тооны өрхөд судалгаа явагдсаныг тооцож, судалгааны энэ онцлогоос гарч болзошгүй эрсдэлийг бууруулахад анхаарах хэрэгтэй. Үнэлгээний хуваарийг **Fehler! Verweisquelle konnte nicht gefunden werden.**-гаас харж болно. Үр дүнгийн үнэлгээг дараах шалгуураар хийнэ. Үүнд:

- Амьжиргааны түвшний шалгуурууд (нүүлгэн шилжүүлж буй өвөлжөөнд хамаатай)
 - Шинэ өвөлжөөг албан ёсоор бүртгүүлсэн эсэх
 - Хуучин өвөлжөө байсан газартай харьцуулахад нийгмийн үйлчилгээ авах боломж хэр байна вэ (сургууль, эмнэлэг, зам, малын түүхий эд худалдаалах газар гэх мэт)
 - Ундны усны эх үүсвэр, өвөлжөөнөөс алслагдах зай
 - Сүүлийн 6 сард тансаг хэрэглээнд зарцуулсан зардал
 - Сүүлийн 12 сард малаас олсон орлого
- Амьжиргаа сэргэснийг нотлох шалгуурууд (эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн зуслангийн бэлчээр ашиглагчид болон өвөлжөөний эздэд хамаатай)
 - Малын тоо толгой
 - Малаас орсон орлого
 - Усны нөөцөд хүрэх боломж, усны чанар

2.5 жилийн турш явагдах мониторинг бүрийн төгсгөлд зөвлөх мэргэжилтэн ССП төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн амьдралын нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөд дүн шинжилгээ хийнэ. Түүнчлэн, тухайн зөвлөх мэргэжилтэн өөрийн хийсэн ажиглалт, дүн шинжилгээг тайлан хэлбэрээр бичиж танилцуулна.

7.1.3 НШТ-ний хэрэгжилтэд хийх аудит

НШТ-ний хэрэгжилтийн аудит нь тус төлөвлөгөө тавьсан зорилгоо гүйцэлдүүлсэн эсэхийг үнэлэх зорилготой. Өөрөөр хэлбэл, бодит болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн өрхүүдийн амьдралын түвшинг сайжруулах, эсвэл хуучин хэвэнд нь сэргээх зорилгоо биелүүлсэн эсэхийг үнэлж дүгнэх зорилготой юм. НШТ-ний хэрэгжилтийн аудитыг өрхийн амьжиргаа нөхөн сэргээгдэхэд хангалттай хугацаа өнгөрсний дараа, НШТ-ний нийцлийн аудитаар мэргэшсэн хүнээр хийлгэх шаардлагатай.

Зураг 7.1 Мониторинг ба үнэлгээ хийх хугацаа

Мониторинг, үнэлгээ	2014				2015				2016				2017				2018			
	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Q3	Q4
ССП-ийн барилга угсралт																				
Дотоод (гүйцэтгэлийн) мониторинг																				
Үр дүнгийн үнэлгээ																				
Төгсгөлийн аудит																				

7.2 Тайлагнах

Мониторингийн үйл явцыг ССП компанийн нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан, байгаль орчны мэргэжилтэнтэй хамтран ажиллахаар төлөвлөгөөнд тусгагдсан. Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн дотоод мониторингийн тайланг тогтмол гаргахын зэрэгцээ мониторингтой холбоотой бусад үйл ажиллагааг хариуцна. Эрх бүхий багийн бэлтгэсэн мониторингийн тайлангуудыг ССП-ийн ажилтан үнэлж, сонирхогч талуудыг мэдээллээр хангах үүрэгтэй.

Хүснэгт 7.2 Тайлан

Тайлан	Агуулга
Төслийн талбай дээрх ажилтан Байгаль орчин, нийгмийн удирдлагын хэлтэст сар бүр тайлан гаргаж танилцуулна	НШТ-ний хэрэгжилтийн байдал (Хүснэгт 7.1-т үзүүлсэнчлэн) Олон нийтийн сэтгэл ханамжийн шалгуурууд (Хүснэгт 7.1-т үзүүлсэнчлэн) Олон нийттэй харилцах үйл ажиллагаа. - Олон нийттэй харилцахад төлөвлөсөн үйл ажиллагаа. - Санал, гомдол - Хүсэлт
Хувь нийлүүлсэн корпорацийн түвшинд Зээлдүүлэгч нарт жил бүр тайлан гаргаж танилцуулна	Жил бүр явагдах эдийн засаг, нийгэм, байгаль орчинтой холбоотой үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээх.

8 ТӨСӨВ

НШТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг тооцохдоо ССП компанийн хүний нөөц болон түүний хэрэгжилтэд оролцох шаардлагатай зөвлөхүүдэд зарцуулагдах зардлыг тооцоогүй болно. Энэхүү төсвийн задаргаа нь нууцлалтай тул зөвхөн ССП компанид хадгалагдана.

НШТ-ний нийт төсөв нь 90000 ам.дол. бөгөөд энэ дүн төслийн тасалбар болгох өдөрт нөхөн төлбөр авах эрх бүхий өрхийн тоо хэд байхаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой.

Хүснэгт 8.1 Төсвийн тойм

Нүүлгэн шилжүүлэлтийн төрөл	Ам.доллар
Бодит нүүлгэн шилжүүлэлтэд олгох нөхөн төлбөр	53,000
Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд олгох нөхөн төлбөр	37,000
Нийт	90,000 ам.дол.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Chu, A.H.S (2014) The Herder's Life in 21st-Century Mongolia, *Journal of Integrated Studies*, Vol. 5, No. 2 Equator Principles (2013), http://www.equator-principles.com/documents/Equator_Principles.pdf

[Fernando-Gimenez, M.E. \(2006\) Land Use and Land Tenure in Mongolia: A Brief History and Current Issues, USDA Forest Service Proceedings RMRS-P-39](#)

[IEA \(2016\) IEA Wind Task 19 – Available Technologies of Wind Energy in Cold Climates,
http://www.ieawind.org/task_19.html](#)

[IFC \(2012\) Performance Standards on Social & Environmental Sustainability,
http://www.ifc.org/wps/wcm/connect/115482804a0255db96fbffd1a5d13d27/PS_English_2012_Full-Document.pdf?MOD=AJPERES](#)

IFC (1998) A Good Practice Manual: Doing Better Business through Effective Public Consultation and Disclosure,
[http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/p_pubconsult/\\$FILE/PublicConsultation.pdf](http://www.ifc.org/ifcext/enviro.nsf/AttachmentsByTitle/p_pubconsult/$FILE/PublicConsultation.pdf)

IFC (2012) Guidance Notes: Performance Standards on Social & Environmental Sustainability,
<http://www.ifc.org/ifcext/sustainability.nsf/Content/GuidanceNotes>

[IFC \(2015\) Wind Energy Environmental, Health and Safety Guideline,
http://www.ifc.org/wps/wcm/connect/2c410700497a7933b04cf1ef20a40540/FINAL_Aug+2015_Wind+Energy_EHS+Guideline.pdf?MOD=AJPERES](#)

IRENA (2015) Renewable Readiness Assessment,
http://www.irena.org/DocumentDownloads/Publications/IRENA_RRA_Mongolia_2016.pdf

Jamsranjav, C (2009) Sustainable Rangeland Management in Mongolia: The Role of Herder Community Institutions, *Land Restoration Training Programme*, Keldnaholt, 112 Reykjavik, Iceland

Mari, Kazato (2006) The State Policy and Herders' Right to Winter Camps (o'voljoo) in Postsocialist Mongolia, Biennial Conference of IASCP (International Association for the Study of Common Property), in Bali Indonesia, June 19-23, 2006,
http://www.ipc.hokusei.ac.jp/~z00592/img/Kazato2006LocalValueAndRights_IASCP.pdf

Ministry of Energy (2016) Energy Sector of Mongolia: Sustainable Development Policy
http://www.switch-asia.eu/fileadmin/user_upload/RPSC/event/23-25May16-Mongolia/23May/5_Yeren_Energy_English.pdf

Mongolian Census Data, (2016) <http://www.1212.mn/statHtml/statHtml.do>

Oyu Tolgoi (2015) Resettlement Action Plan, www.ot.mn

SWP Project Environmental Impact Assessment (EIA), Mongolia EIA Final Report (2014)
http://www.eic.mn/eia/generalreport.php?menuitem=1&count=10&page=1&project_type=5&project_aim_ag=44&action=more&generalreport_id=4172

SWP Project Environmental Impact Assessment (EIA), Mongolia DEIA Final Report (2015)

http://www.eic.mn/eia/eiareport.php?menuitem=1&count=10&page=1&org_name=20&project_aimag=44&action=more&eiareport_id=4634

SWP Project Environmental and Social Due Diligence Report (ESDD), Mongolia ESDD Final Report (2016)

[VTT \(2010\) Recommendations for Wind Energy Projects in Cold Climates.](http://www.vttresearch.com/impact/publications)

<http://www.vttresearch.com/impact/publications>

World Bank (2016) Land Acquisition and Resettlement Legal Framework Terms of Reference,

<http://documents.worldbank.org/curated/en/585621468277494387/text/RP11910v20P1220nnexes0003100802011.txt>

Хавсралт А: Өрхийн судалгааны хуудас

№1. Өрхийн тэргүүний нэр:					Ам бүл:	Харьяалал:	Утасны дугаар:						
№	Гэр бүлийн гишүүдийн нэр	Гэр бүлийн хэн болох	Нас	Хүйс	Регистрийн дугаар	Боловсрол	Мэргэжил	Эрхэлж буй ажил	Утасны дугаар	Ямар төрлийн нийгмийн халамж үйлчилгээ авдаг вэ	Эрүүл мэндийн байдал	Тээврийн ямар хэрэгсэлтэй вэ	Сарын орлогын эх үүсвэр
1													
2													
3													
4													
№	Өвөлжөөний байршил	Хаваржааны байршил	Зуслангийн байршил	Өвөлжөөний газрыг ашиглах зөвшөөрөлтэй юу?	Тухайн газрыг бэлчээрт ашигласан жил	Ямар төрлийн малтай вэ?	Малын тоо толгой						
Нэмэлт мэдээлэл:													

Хавсралт Б: Олон нийтийн санал, гомдлын хуудас

Би, (овог, нэр)

Хэрэв нэрээ нууцалсан бол ☐ энэ дөрвөлжинд тэмдэглэгээ хийн дараагийн хэсгүүдийг бөглөнө үү.

Дараах хаягт оршин суудаг:

 y_{Tac}

Факс:

Жич: Хэрэв нэрээ нууцалсан бол энэ хэсгийг бөглөх шаардлагагүй.

Дараах гомдол / саналыг гаргаж байна (асуудал бүхий газрын байршил, асуудлын цаг хугацааг бичнэ):

Асуудлыг шийдэх санал:

Харилцааны сувгаа сонгох (шууд: ☐ нүүр тулан, ☐ утас; бичгэн хэлбэр: ☐ e-mail, ☐ онлайн):

Гарын үсэг:

Огноо:

Хэрэв нэрээ нууцалсан бол зөвхөн огноог бөглөнө үү.